МОНГОЛ УЛСЫН
АЖ ҮЙЛДВЭР,
ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД

Засгийн газрын II байр, Нэгдсэн үндэстний гудамж 5/1,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-51) 26 35 06,
Цахим шуудан: info@mimr.gov.mn,
Цахим хуудас: www.mimr.gov.mn

2025.02.11 № 01/439

танай ____________-ны №______________-т

ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНД

Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн Үндэсний геологийн албаны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг тайлангийн хамт үүгээр хүргүүлж байна.

Хавсралт 52 хуудастай

Ц.ТУВААН

АА14031 9129294
9024120060

1598 08 0262

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны
Төрийн нарийн бичгийн даргын
2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн
01/439 дугаартай албан бичгийн хавсралт

ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА
/2024 оны жилийн эцэс/

2025 оны 02 дугаар сарын 10

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Төсвийн ерөнхийлөн захирагч (Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд)-аас төсвийн шууд захирагч (Үндэсний геологийн албаны дарга)-тай зөвшилцөн баталсан Үндэсний геологийн албаны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зорилтыг хүрэх түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй**.

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, Засгийн газрын 2020 оны "Журам шинэчлэн батлах тухай" 217 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн Үндэсний геологийн албаны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 5 зорилго, 27 зорилтын хүрээнд 83 арга хэмжээний биелэлтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

**Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд илэрсэн зөрчил, дутагдал**.

Хяналтад авсан Үндэсний геологийн албаны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 5 зорилго, 27 зорилтын хүрээнд 83 арга хэмжээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах зөрчил, дутагдал илэрсэн тул холбогдох санал, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна. Үүнд:

**ЗОРИЛГО 1. "Улсын төсвийн хөрөнгөөр нутаг дэвсгэрийн геологи, геофизик, геохими, гидрогеологи, геоэкологи, геотехникийн зэрэг зураглал, судалгаа, шинжилгээний ажлыг үе шаттай төлөвлөх, гүйцэтгэх, удирдах"**

- 1.2.1. дэх зорилтод "Геологийн судалгааны ажил гүйцэтгэх түүнд тавигдах шаардлага, зааврыг батлуулсан байна." гэж тусгагдсан боловч тайланд энэхүү зааврыг батлуулсан эсэх нь тодорхойгүй байна.
- 1.5.2. дахь зорилтод тусгагдсан УГЗ-200 М лист нэгтгэл төслийн гэрээний хугацааг ямар шалтгаанаар сунгасан мөн эцсийн тайланг хүлээн авсан эсэх нь тодорхойгүй байна.
- 1.5.3. дахь зорилтын хүрээнд УГЗ-200 М лист нэгтгэл төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлж хүлээн авсан эсэх тодорхойгүй байна.
- 1.6.2. дахь зорилтод тусгагдсан Дархан хотын нутаг дэвсгэрт 1:25000-ны масштабын геоэкологи, гидрогеологийн зураглал, дагалдах мэдээллийн сан бүхий үр дүнгийн тайланд засвар хийн дахин ЭБМЗ-өөр хэлэлцүүлсэн эсэх тодорхойгүй байна.
- 1.8.1. дэх зорилтод тусгагдсан Монгол орны нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд Мезо-Кайнозойн хурдсын тархалт, зүй тогтол, ашигт малтмалын хэтийн төлөвийн үнэлгээ өгөх "Мезо-Кайнозой-2021" төслийн гэрээний хугацааг ямар шалтгаанаар сунгасан

эсэх мөн тайланг хүлээн авч, Монгол Улсын эрдэс баялгийн мэдээллийн санд бүртгүүлсэн эсэх тодорхойгүй байна.

**ЗОРИЛГО 2. "Ашигт малтмалын тархалтын зүй тогтол, минерагений суурь судалгаа хийж, эрдэс баялгийн хэтийн төлөвийн үнэлгээ өгөх, улс орны эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ашигт малтмалын эрлийн болон хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахуйц бүс, зангилгаа, талбайг ялгах ажлыг зохион байгуулах"**

- 2.1.1. дэх зорилтод тусгагдсан Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа ӨТТЭ-2, БМШАМ, ЭҮ-4 эрдэс баялгийн сэдэвчилсэн судалгаа төслүүдийн гэрээний хугацааг ямар шалтгаанаар сунгасан мөн тайланг хүлээн авч, Монгол Улсын эрдэс баялгийн мэдээллийн санд бүртгүүлсэн эсэх тодорхойгүй байна.
- 2.3.1. дэх зорилт аль байгууллагын чиг үүрэгт хамаарч байгаа нь тодорхойгүйгээс биелэлт гарах боломжгүй байна.

**ЗОРИЛГО 3. "Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн төрөлжсөн, нэгдсэн сан бүрдүүлэх, баяжуулах, боловсруулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах"**

- 3.2.3. дахь зорилтод Ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд шинээр 100 ордын тайлангийн үр дүнг шинээр нэмж бүртгэнэ гэсэн боловч 65 нөөцийн мэдээлэл бүртгэсэн байна.

**ЗОРИЛГО 4. "Төрийн захиргааны төв байгууллагад геологийн судалгааны бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, холбогдох төрийн захиргааны болон судалгааны байгууллагатай гидрогеологи, геофизик, геоэкологи, мөн түүнчлэн ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч, газрын тосны эрлийн, гэрээлэгчийн хайгуул, ашиглалтын талбайд хамаарах мэдээллээр улсын геологийн фонд, баримтын төвийг арвижуулан, харилцан үйлчилгээ үзүүлэх"**

- 4.2.3 дахь зорилтод тусгагдсан онлайн лавлагааны систем нэвтэрсэн эсэх тодорхойгүй байна.
- 4.4.2 дахь зорилтод тусгагдсан "Геологийн баримтын төв архивд геологийн судалгааны тайлан хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, үйл ажиллагааг зохицуулах дотоод журам"-ыг боловсруулсан боловч батлуулсан эсэх нь тодорхойгүй байна.
- 4.4.3 "Техник, эдийн засгийн үндэслэл, Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, Зураглалын тайлан архивд хүлээн авах заавар"-ыг боловсруулсан боловч батлуулсан эсэх нь тодорхойгүй байна.

**ЗОРИЛГО 5. "Төрийн захиргааны удирдлагын манлайлал, хүний нөөцийн удирдлагаар хангах, байгууллагын хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг оновчтой удирдах, тайлагнах, албаны үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, стандарт боловсруулах, батлуулах, мөрдүүлэхэд эрх зүйн дэмжлэг үзүүлэх, салбарын хэмжээнд байгуулагдах гэрээ, хэлэлцээр хийх ажлыг зохион байгуулах, салбарыг сурталчлах, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудлыг эрхлэх, гадаад орнууд, олон улсын геологийн алба, байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх"**

- 5.3.2 Геологи судалгааны чиглэлээрх холбогдох дүрэм журмыг боловсронгуй болгох, хэрэгжилтэд хяналт тавина гэсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хүрээнд ажил хийгдсэн эсэх тодорхойгүй байна.
- 5.4.7 Мөн 2024 онд гүйцэтгэхээр төсөвт тусгагдсан ҮГА-ны байрны дээврийн засвар, ариун цэврийн өрөөнүүдийн засвар, барилгын дотоод засварын ажил үйлчилгээний тендер амжилтгүй болсон шалтгаан тодорхойгүй байна.

# ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ
## /2024 оны жилийн эцэс/

| Зорилго, зорилт | Арга хэмжээний тоо | Хэрэгжилтийн явц /хувиар/ | | | | | | | Үнэлгээ /хувиар/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 | /-/ | |
| **ЗОРИЛГО 1. Улсын төсвийн хөрөнгөөр нутаг дэвсгэрийн геологи, геофизик, геохими, гидрогеологи, геоэкологи, геотехникийн зэрэг зураглал, судалгаа, шинжилгээний ажлыг үе шаттай төлөвлөх, гүйцэтгэх, удирдах** | | | | | | | | | |
| Зорилт 1.1.1:50000-ны масштабын геологийн зураглал,ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлж, нутаг дэвсгэрийн 47%-ийг хамруулах /ЗГҮАХ-АХТ 3.2.3.1/. | 5 | 4 | 1 | /-/ | /-/ | /-/ | /-/ | /-/ | 98 |
| Зорилт 1.2.1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглалын ажлыг эхлэх, нутаг дэвсгэрийн 0.15 хувийг хамруулна. /ЗГҮАХ-АХТ 3.2.3.2/. | 1 | /-/ | /-/ | /-/ | 1 | /-/ | /-/ | /-/ | 50 |
| Зорилт 1.3. Геохимийн 1:1000000-ын масштабын зураг зохиох ажлыг хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийг 100% хамруулах /ЗГҮАХ-АХТ 3.2.3.5/. | 1 | 1 | /-/ | /-/ | /-/ | /-/ | /-/ | /-/ | 100 |
| Зорилт 1.4. Улсын төсвийн хөрөнгөөр явуулж байгаа үйл ажиллагааг эрхлэх, гэрээгээр гүйцэтгүүлсэн ажилд хяналт тавих, тайланг хүлээн авч хянах, холбогдох дүгнэлт гаргах замаар геологи судалгааны ажлыг удирдан чиглүүлэх /ҮГАСТ.Зорилт-1.2./. | 2 | 2 | /-/ | /-/ | /-/ | /-/ | /-/ | /-/ | 100 |
| Зорилт 1.5. Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрэн зургийг нэгтгэж дуусгах, нутаг дэвсгэрийн 100 хувийг хамруулах. /ЗГҮАХ-АХТ 3.2.3.3/. | 4 | 1 | /-/ | 3 | /-/ | /-/ | /-/ | /-/ | 77.5 |
| Зорилт 1.6. Агаарын геофизикийн 1:200000-ны масштабын соронзон судалгааны ажлыг хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийн 70 хувийг хамруулах /ЗГҮАХ-АХТ 3.2.3.4/. | 2 | 2 | /-/ | /-/ | /-/ | /-/ | /-/ | /-/ | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 1.7. Бүс нутаг болон хотуудын геоэкологи, гидрогеологи, геотермийн судалгааны ажил хийх. /ЗГҮАХ-АХТ 3.2.3.6/. | 3 | 1 | /-/ | 2 | /-/ | /-/ | /-/ | /-/ | 80 |
| Зорилт 1.8 Геологийн өв, тулгуур зүсэлт, онцлог тогтоц, тектоник, минерагенийн болон геохими, геофизик, энергийн түүхий эдийн хэтийн төлөвийн сэдэвчилсэн судалгааны ажил хийх /ЗГҮАХ-АХТ 3.2.3.7/. | 3 | 2 | /-/ | /-/ | 1 | /-/ | /-/ | /-/ | 83.3 |
| **Дүн** | **21** | **13** | **1** | **5** | **2** | **/-/** | **/-/** | **/-/** | **86** |
| **ЗОРИЛГО 2. Ашигт малтмалын тархалтын зүй тогтол, минерагений суурь судалгаа хийж, эрдэс баялгийн хэтийн төлөвийн үнэлгээ өгөх, улс орны эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ашигт малтмалын эрлийн болон хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахуйц бүс, зангилгаа, талбайг ялгах ажлыг зохион байгуулах** | | | | | | | | | |
| Зорилт 2.1. Өндөр технологийн түүхий эд болох газрын ховор элемент, үнэт, өнгөт, хар, холимог металл, металл бус ашигт малтмал болон газрын тосны эрэл,хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эрдэс баялгийн нөөцийг арвижуулах /Шинэ сэргээлтийн бодлого-3.1.2, ЗГҮАХ-3.2.5/. | 3 | 2 | /-/ | 1 | /-/ | /-/ | /-/ | /-/ | 90 |
| Зорилт 2.2. Улсын төсвийн хөрөнгөөр явуулж байгаа үйл ажиллагааг эрхлэх, гэрээгээр гүйцэтгүүлсэн ажилд хяналт тавих, тайланг хүлээн авч хянах, холбогдох дүгнэлт гаргах замаар геологийн судалгааны ажлыг удирдан чиглүүлэх /ЗГҮАХ-АХТ 3.2.3/ | 1 | 1 | /-/ | /-/ | /-/ | /-/ | /-/ | /-/ | 100 |
| Зорилт 2.3. Улсын төсвийн хөрөнгөөр геологи-хайгуулын ажил хийгдсэн ордыг ашиглаж байгаа хуулийн этгээдээс АМТХ-д заасан зардлыг төсөвт төвлөрүүлэхэд шаардлагатай тооцоо хийх | 1 | /-/ | /-/ | /-/ | /-/ | /-/ | /-/ | /-/ | /-/ |
| **Дүн** | **4** | **3** | **/-/** | **1** | /-/ | **/-/** | /-/ | **/-/** | **63.3** |
| **ЗОРИЛГО 3. Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн төрөлжсөн, нэгдсэн сан бүрдүүлэх, баяжуулах, боловсруулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах** | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 3.1.Хэрэглэгчийг мэдээллээр түргэн шуурхай найдвартай хангах зорилгоор Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн нэгдсэн цахим санг баяжуулах /ЗГҮАХ 3.2.4/. | 3 | 3 | /-/ | /-/ | /-/ | /-/ | /-/ | /-/ | 100 |
| Зорилт 3.2. Хэрэглэгчийг мэдээллээр шуурхай, найдвартай хангах геологийн төрөл бүрийн мэдээллээр төрөлжсөн нэгдсэн цахим сан бүрдүүлэх, баяжуулах, боловсруулах /ЗГҮАХ 3.2.4/. | 4 | 3 | /-/ | 1 | /-/ | /-/ | /-/ | /-/ | 92.5 |
| Зорилт 3.3. Төрийн цахим ой санамж болох мэдээллийн сан, өгөгдлийн бүрэн бүтэн, нэгдмэл, аюулгүй байдлыг хангаж нэг эх сурвалж бүхий мэдээлэл, нээлттэй өгөгдлийг бий болгон хөгжүүлж, төрийн үйлчилгээний нэгдсэн системтэй холбох, төрийн үйлчилгээг түргэн шуурхай болгох /2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 5.3/. | 2 | 2 | /-/ | /-/ | /-/ | /-/ | /-/ | /-/ | 100 |
| Зорилт 3.4. Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд гүйцэтгэсэн геологийн болон сэдэвчилсэн судалгааны ажлын үр дүнгээр тогтоогдсон, сонгон шалгаруулалтаар олгох боломжтой, ашигт малтмалын хэтийн төлөвтэй талбайн мэдээллийг нэгтгэж холбогдох төрийн захиргааны төв байгууллагыг мэдээллээр хангах | 1 | 1 | /-/ | /-/ | /-/ | /-/ | /-/ | /-/ | 100 |
| Зорилт 3.5. Монгол Улсын ашигт малтмалын ордын нөөцийн тэнцэл /баланс/ гаргах, тайлагнах, хөтлөх | 1 | /-/ | /-/ | 1 | /-/ | /-/ | /-/ | /-/ | 70 |
| **Дүн** | **11** | **9** | /-/ | **2** | /-/ | /-/ | /-/ | /-/ | **92.5** |

**ЗОРИЛГО 4. Төрийн захиргааны төв байгууллагад геологийн судалгааны бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, холбогдох төрийн захиргааны болон судалгааны байгууллагатай гидрогеологи, геофизик, геоэкологи, мөн түүнчлэн ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч, газрын тосны эрлийн, гэрээлэгчийн хайгуул, ашиглалтын талбайд хамаарах мэдээллээр улсын геологийн фонд, баримтын төвийг арвижуулан, харилцан үйлчилгээ үзүүлэх.**

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 4.1 Архивын баримтын аюулгүй байдлын баталгааг хангаж, хадгалалт хамгаалалтыг сайжруулах шат дараалсан арга хэмжээ авах /ҮГА-ны Стратеги төлөвлөгөө 4.1/ | 4 | 4 | /-/ | /-/ | /-/ | /-/ | /-/ | /-/ | 100 |
| Зорилт 4.2. Архивын үйлчилгээг боловсронгуй болгох, зохион байгуулах /ҮГА-ны Стратеги төлөвлөгөө 4.2/ | 3 | 2 | /-/ | 1 | /-/ | /-/ | /-/ | /-/ | 90 |
| Зорилт 4.3. Газрын хэвлийн тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомжуудын хүрээнд газрын хэвлийд хийгдсэн бүх төрлийн судалгааны ажлын тайлан мэдээг нэгтгэн хүлээн авах, тайлан мэдээг тогтмол гаргах | 3 | 3 | /-/ | /-/ | /-/ | /-/ | /-/ | /-/ | 100 |
| Зорилт 4.4. Архивын үйл ажиллагааг олон улсын, ижил төстэй архивын сан хөмрөгтэй харьцуулан судалж, нэгдсэн бүртгэлд гишүүнчлэлээр элсэж, үйл ажиллагааг тогтмол сайжруулах | 3 | 1 | /-/ | 2 | /-/ | /-/ | /-/ | /-/ | 80 |
| Зорилт 4.5. Иргэд, хуулийн этгээдэд Төрийн архивын баримтаар түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх, Улсын төсөвт орлого төвлөрүүлэх | 1 | 1 | /-/ | /-/ | /-/ | /-/ | /-/ | /-/ | 100 |
| **Дүн** | **14** | **11** | **/-/** | **3** | /-/ | /-/ | **/-/** | **/-/** | **94** |
| **ЗОРИЛГО 5. Төрийн захиргааны удирдлагын манлайлал, хүний нөөцийн удирдлагаар хангах, байгууллагын хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг оновчтой удирдах, тайлагнах, албаны үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, стандарт боловсруулах, батлуулах, мөрдүүлэхэд эрх зүйн дэмжлэг үзүүлэх, салбарын хэмжээнд байгуулагдах гэрээ, хэлэлцээр хийх ажлыг зохион байгуулах, салбарыг сурталчлах, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудлыг эрхлэх, гадаад орнууд, олон улсын геологийн алба, байгууллагатай хамтын ажиллагаа хөгжүүлэх** | | | | | | | | | |
| Зорилт 5.1. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах /ҮГА-ны Стратеги төлөвлөгөө 5.1/ | 11 | 11 | /-/ | /-/ | /-/ | /-/ | /-/ | /-/ | 100 |
| Зорилт 5.2. Салбарын мэргэжилтэй боловсон хүчний чадавхыг дээшлүүлэх, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах | 2 | 2 | /-/ | /-/ | /-/ | /-/ | /-/ | /-/ | 100 |
| Зорилт 5.3. Үндэсний геологийн албаны Стратеги төлөвлөгөөний 5 дугаар зорилго, Зорилт 2. Салбарын хууль, эрх зүйн орчны | 3 | /-/ | /-/ | 1 | 1 | /-/ | 1 | /-/ | 40 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| харилцааг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх | | | | | | | | | |
| Зорилт 5.4. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төсвийн гүйцэтгэлд хяналт тавих /Төсөв хуваарилах, зарцуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах эрхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/06 дугаар тушаал/. | 7 | 6 | /-/ | /-/ | 1 | /-/ | /-/ | /-/ | 92.8 |
| 5.5 Төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлэх | 4 | 3 | /-/ | 1 | /-/ | /-/ | /-/ | /-/ | 92.5 |
| Зорилт 5.6. Байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх санал боловсруулах, тайлагнах, хариуцлага тооцох, урамшуулах, дотоодын хяналтын тогтолцоог сайжруулах, 2023 оны зорилтот түвшин, хүрсэн түвшний зөрүүг бууруулах. | 5 | 5 | /-/ | /-/ | /-/ | /-/ | /-/ | /-/ | 100 |
| **Дүн** | **32** | **27** | /-/ | **2** | **2** | /-/ | **1** | /-/ | **87.5** |
| **Нийт дүн** | **83** | **63** | **1** | **13** | **4** | /-/ | **2** | /-/ | **90.36** |

**Дөрөв. Дүгнэлт.**

1. Үндэсний геологийн албаны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 2024 оны 12 дугаар сарын байдлаар **90.36** хувь үнэлэгдсэн бөгөөд ерөнхий 5 зорилго, 27 зорилтын хүрээнд 83 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсаны зорилтод түвшинд хүрч 90-100 хувийн гүйцэтгэлтэй 64, үр дүн тодорхой хэмжээгээр гарч, боловсруулалтын шатанд байгаа буюу 50-70 хувийн гүйцэтгэлтэй 17, гүйцэтгэл хангалтгүй буюу үнэлэх боломжгүй 2 арга хэмжээ байна гэж дүгнэлээ.

**Тав. Зөвлөмж.**

1. Цаашид Үндэсний геологийн албаны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичиг, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2024-2028 оны стратеги төлөвлөгөө болон танай байгууллагын үндсэн чиг үүрэгт хамаарах төсөл хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжихүйц, бодитой боловсруулж тусгах;
2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго, зорилтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, төсөл хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө, хүрсэн үр дүнг оновчтой байдлаар тайлагнах, холбогдох баримт нотолгоог тухай бүр цуглуулж тайланд хавсаргах /холбогдох хууль тогтоомж, тушаал шийдвэр, тайлан хүлээн авсан тухай баримт,

судалгааны тайланд хяналт тавьсан тухай баримт, санхүүгийн баримт болон албан бичгийн огноо г.м./;

Жич: Үндэсний геологийн албаны 2024 гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай тайланг үнэлгээний хамт хавсаралтаар хүргүүлж байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны
Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны
02 дугаар сарын 11-ний өдрийн 01/139 дугаартай
албан бичгийн 2 дугаар хавсралт

## ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

| Д/д | № | "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /ЗГҮАХ-АХТ/, Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын стратеги төлөвлөгөө /2020-2024/, Үндэсний геологийн албаны стратеги төлөвлөгөө /2020-2024/, УУХҮЯ-ны Гүйцэтгэлийн төлөвлөгөө-2024 | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт / хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь /ҮГА-ны ХШҮДАГ/ | Гүйцэтгэлийн хувь /АҮЭБЯ-ны ХШҮДАГ/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **ЗОРИЛГО 1. Улсын төсвийн хөрөнгөөр нутаг дэвсгэрийн геологи, геофизик, геохими, гидрогеологи, геоэкологи, геотехникийн зэрэг зураглал, судалгаа, шинжилгээний ажлыг үе шаттай төлөвлөх, гүйцэтгэх, удирдах** | | | | | | | | | |
| Зорилт 1.1.1:50000-ны масштабын геологийн зураглал,ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлж, нутаг дэвсгэрийн 47%-ийг хамруулах /ЗГҮАХ-АХТ 3.2.3.1/. | | | | | | | | | |
| 1 | 1.1.1 | Монгол Улсын нутаг дэвсгэрийн 45487.85 км.кв талбайд хэрэгжиж буй 12 төслийн 2024 оны геологийн судалгааны ажлын төлөвлөгөө, төсвийг хянан, баталгаажуулна:<br>-Цагаан овоо-50, Индэртийн нуруу-50, Загал уул-50, Ямаат уул-50, Бөөн хөх уул-50, Буйлст хүрэн уул-50, Баянзүрх уул-50, | - | ЭБМЗ-ийн хурлаар төсвийн тодотголыг хэлэлцүүлсэн төслийн тоо | 0 | 12 | Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй геологийн судалгааны Цагаан овоо-50, Индэртийн нуруу-50, Загал уул-50, Ямаат уул-50, Бөөн хөх уул-50, Буйлст хүрэн уул-50, Баянзүрх уул-50, Ханхар уул-50, Үүрэг нуур-50, Мөст уул-50, Ямбат уул-50, Овоот шар – 50 төслүүдийн 2024 оны төсвийн тодотголыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн УТХ-2024-01, УТХ-2024-02, УТХ-2024-03 хурлаар оруулсан. | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Ханхар уул-50, Үүрэг нуур-50, Мөст уул-50, Ямбат уул-50, Овоот шар – 50. | | | | | *Хүрсэн түвшин: 12 төслүүдийн 2024 оны ажлын тоо хэмжээ, арга аргачлал, төлөвлөгөөг баталж, төсвийг 3,498.17 сая төгрөгөөр батлуулж, АҮЭБЯ-нд 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 1/305 дугаар албан бичгээр цаг хугацаанд нь хүргүүлсэн.* | | |
| 2 | 1.1.2 | Монгол орны 16983.63 км.кв нутаг дэвсгэрийг хамарсан геологийн тогтоц, ашигт малтмалын судалгааны ажлыг гүйцэтгэж буй Баянзүрх уул-50, Ханхар уул-50, Үүрэг нуур-50, Мөст уул-50, Ямбат уул-50, Овоот шар-50 төслүүдийн хээрийн ажлын хэрэгжилтийг хангаж, хяналт тавина. | - | Хээрийн шуурхай хяналт хийсэн төслийн тоо | 0 | 6 | Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй геологийн судалгааны нийт 16,983.63 км.кв талбайг хамрах Үүрэг нуур-50, Мөст уул-50, Овоот шар – 50 төлүүдэд 2024 оны 7 дугаар сарын 22-ноос 31-ний хооронд Баянзүрх уул-50, Ханхар уул-50 төслүүдэд, 2024 оны 08 дугаар сарын 08 дугаар сарын 13-нд Ямбат уул-50 төсөлд, 2024 оны 08 дугаар сарын 19-нөөс 8 дугаар сарын 22-нд нийт 6 төслийн 2024 оны ЭБМЗ-өөс батлагдсан хээрийн судалгааны ажлын арга аргачлал, тоо хэмжээ, чанар, үр дүнд хяналт хийсэн.<br>*Хүрсэн түвшин: 6 төслийн гүйцэтгэлд шуурхай хяналт хийж, зөвлөмжөөр хангасан.* | 100 | 100 |
| 3 | 1.1.3 | Монгол орны 9658.12 км.кв нутаг дэвсгэрийг хамарсан Цагаан-Овоо-50, Индэртийн нуруу-50, Загал уул-50, Бөөн хөх уул-50, Ямаат уул-50, Буйлст хүрэн уул-50 төслүүдийн тайлан боловсруулалтын чанар, үр дүн, ажлын даалгаврын биелэлтэд хяналт тавина. | - | Тайлангийн шуурхай хяналт хийсэн төслийн тоо | 0 | 6 | Үндэсний геологийн албаны даргын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан томилолтын удирдамжийн дагуу 2024 оны 05 дугаар сарын 27-ноос 06 дугаар сарын 07-ны өдрүүдэд Цагаан-Овоо-50, Идэртийн нуруу-50, Загал уул-50, Бөөн хөх уул-50, Буйлст хүрэн уул-50 төслүүдийн тайлан боловсруулалтын чанар, үр дүн, ажлын даалгаврын биелэлтэд хяналт хийсэн.<br>Хөвсгөл аймгийн харьяат ААН-ийн хэрэгжүүлж байгаа Ямаат уул-50 төсөлд 2024 оны 08 дугаар сарын 12-ноос 13-ний өдрүүдэд ажлын хэсэг хөдөө орон нутагт томилолтоор очиж ажиллан, төслийн үр дүнгийн тайлан боловсруулалтын чанар, үр дүн, ажлын даалгаврын биелэлтэд хяналт хийсэн.<br>*Хүрсэн түвшин: Нийт 6 төсөлд тайлангийн шуурхай хяналт хийсэн.* | 100 | 100 |
| 4 | 1.1.4 | Улсын төсвийн хөрөнгөөр 2020-2024 онд 77,369,9 км.кв талбайд хэрэгжиж буй 20 төслийн үр дүнг | - | Монгол Улсын нутаг дэвсгэрийг геологийн | 45.15% | 50.06% | 2024 онд Монгол орны нутаг дэвсгэрийн 4,05%-ийг хамруулсан доорх төслүүдийг ЭБМЗ-ийн хурлаар оруулж хэлэлцүүлсэн. | 90 | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хүлээн авч, Монгол Улсын эрдэс баялгийн мэдээллийн санд бүртгүүлнэ: Их өлзийт-50, Модот толгой-50, Дөч гол-50, Халзан овоо-50, Алаг баян-50, Өндөр ширээт-50, Оорцог уул-50, Хайрхан овоо-50, Хар хайрхан-50, Овоот толгой-50, Үнэгт уул-50, Их хараат уул-50, Цэцэрлэг-50, Их элээт уул-50, Уушгийн улаан-50, Торлог уул-50, Улаангом-50, Их бэрхийн уул-50, Гилбэнт уул -50, Зангат-50. | | судалгааны ажлаар нэмэгдүүлсэн % /Тайлан ЭБМЗ-ийн хурлаар хамгаалагдсан байна/. | | | Үнд: Дөч гол-50 төсөл цэг 6 Давхарга зүйн нэгж, 2 бүрдэл, 5 илрэл, 162 эрдэсэжсэн цэг ( мангани 841.136 тн, алт 250.96кг, мөнгө 12.936, фольфрам 3.64 тн, төмөр 35,196, зэс 52.5 тн), Халзан овоо-50 төсөл 8 Давхарга зүйн нэгж, 3 бүрдэл, 2 илрэл, 72 эрдэсэжсэн цэг (Мангаан 1,502,400 тн, Зэс 1,936,290 тн), Оорцог уул-50 төсөл 10 Давхарга зүйн нэгж, 3 бүрдэл, 8 илрэл, 193 эрдэсэжсэн цэг (төмөр 103,527 тн), Алаг баян-50 төсөл 16 Давхарга зүйн нэгж, 5 бүрдэл, 10 илрэл, 17 эрдэсэжсэн цэг (17.4кг алт, 94.988 тн зэс, 12,822 тн цайр, 96,416 тн мишъякийн, 170.4 тн сурьма, 100кг мөнгөний баялаг, 33,401.72 тн иттри 43,275.8 тн лантан, 2815.14 тн цери, 27,213.03 тн хар тугалга, 16094.1 тн цери), Өндөр ширээт-50 төсөл 7 Давхарга зүйн нэгж, 7 бүрдэл, 8 илрэл, 35 эрдэсэжсэн цэг (төмөр-214.244 тн, манган-12.054 тн, зэс-217 тн, алт 3.78кг), Хайрхан овоо-50 9 Давхарга зүйн нэгж, 3 бүрдэл, 8 илрэл, 143 эрдэсэжсэн цэг (зэс 41375 тн, төмөр 98.7кг, дайрга 359100м^3, тоосгоны шавар 383600м^3, элс 42250м3, цагаан гантиг 12600м3, ногоон гантиг 25110м3), Уушгийн улаан-50 10 Давхарга зүйн нэгж, 4 бүрдэл, 4 илрэл (зэс-64,690 тн. алт-19.67кг), Овоот толгой-50 6 Давхарга зүйн нэгж, 6 бүрдэл, 7 илрэл, 116 эрдэсэжсэн цэг (алт-4,53т, хар тугалга-1,200 тн, хүнцэл 6,300 тн, Хром-16,500 тн, никель-18,000 тн, кобальт 3,600 тн, шавар 26,460,000м^3, элс 61,700,000м^3) Торлог уул-50 10 Давхарга зүйн нэгж , 3 бүрдэл, 12 илрэл, 123 эрдэсэжсэн цэг (төмөр 954,630 тн, зэс 390,000 тн, берилл 553,890.6 тн, вольфрам 355.82 тн, рубиди 327 тн, хүнцэл 4.5 тн, титан 67,600 тн, висмут 1,352кг, зэс 306 тн, алт 252.252кг), Цэцэрлэг-50 6 Давхарга зүйн нэгж, 6 бүрдэл, 7 илрэл, 116 эрдэсэжсэн цэг (хар тугалга-589.700 тн, цайр-14,140 тн, зэс-38,168 тн, висмут-7,910 тн, молибден-2,395 тн), Их хараат уул-50 14 Давхарга зүйн нэгж, 4 бүрдэл, 5 илрэл, 109 эрдэсэжсэн цэг | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | (шилний түүхий эд 95,400,000 тн, хүнцэл-7811.19 тн, манган-9862.05 тн, төмөр-33,413.32 тн, алт-14,586.6кг, хар тугалга-801,990 тн, мөнгө-51.14 тн, висмут-1098.8 тн, зэс-69.6 тн, цагаан тугалга-19.55 тн, вольфрам-29.11 тн, молибден-114.59 тн), Үнэгт уул-50 8 Давхарга зүйн нэгж, 2 бүрдэл, 5 илрэл, 17 эрдэсжсэн цэг (төмөр 7,200,000 тн, манган 13,500 тн, алт 450кг, мышьяк 5,400 тн, шатдаг занар 1,280,000,000 тн) үр дүн бүхий тайланг УТХ-04-өөс УТХ-09 хуралдаанаар оруулж хамгаалагдсан. ЭБМЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 20-нд зохион байгуулагдах хурлын дэгд орсон Модот толгой-50 16 Давхарга зүйн нэгж, 5 бүрдэл, 10 илрэл, 96 эрдэсжсэн цэг (Сурьма 2375 кг, Флюорит 43000 тн, ураны хүдэр 6200 тн), Гилбэнт уул-50 24 Давхарга зүйн нэгж, 4 бүрдэл, 8 илрэл, 50 эрдэсжсэн цэг (Зэс 1940.6 тн, Алт 103.1кг, мангани 4821.9 тн, мөнгө 991 кг, төмөр 27264 тн, Мышьяк 27264 тн ), Зангат-50 15 Давхарга зүйн нэгж, 5 бүрдэл, 22 илрэл, 220 эрдэсжсэн цэг (Алт 3.5 тн, Вольфрам 63.4 тн, Зэс 51800 тн, Бал чулуу 21300 тн, Зэс 118600 тн) үр дүн бүхий тайлан хамгаалагдсан.<br>*Хүрсэн түвшин: Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 47.9 хувийг хамруулсан,* | | |
| 5 | 1.1.5 | Монгол Улсын нутаг дэвсгэрийн 45487.85 км.кв талбайд хэрэгжиж буй 12 төслийн 2024 оны геологийн судалгааны ажлын гүйцэтгэлийг хянаж, төсвийг баталгаажуулж, үр дүнг хүлээн авна:<br>Цагаан овоо-50, Индэртийн нуруу-50, Загал уул-50, Ямаат уул-50, Бөөн хөх уул-50, Буйлст хүрэн уул-50, Баянзүрх уул-50, Ханхар уул-50, Үүрэг нуур-50, Мөст уул-50, Ямбат уул-50, Овоот шар – 50. | - | Хээрийн материал хүлээн авсан төслийн тоо | 0 | 12 | Үндэсний геологийн албаны даргын 2024 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А-84 дүгээр тушаалаар батлагдсан томилолтын удирдамжийн дагуу 2024 оны 10 дугаар сарын 30-наас 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрүүдэд геологийн судалгааны ажлын Цагаан овоо-50, Индэртийн нуруу-50, Загал уул-50, Ямаат уул-50, Бөөн хөх уул-50, Буйлст хүрэн уул-50, Баянзүрх уул-50, Ханхар уул-50, Үүрэг нуур-50, Мөст уул-50, Ямбат уул-50, Овоот шар – 50 төслүүдийн 2024 онд гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээ, үр дүнд, чанар, хэрэгжилтэд хяналт хийсэн.<br>*Хүрсэн түвшин: 12 төслийн хээрийн материалыг төлөвлөгөөт хугацаанд нийт* | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | *3,521,698,656 төгрөгийн ажил гүйцэтгэлийг хүлээн авсан.* | | |
| Зорилт 1.2.1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглалын ажлыг эхлэх, нутаг дэвсгэрийн 0.15 хувийг хамруулна. /ЗГҮАХ-АХТ 3.2.3.2/. | | | | | | | | | |
| 6 | 1.2.1 | 1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглалын ажлыг эхлэх, нутаг дэвсгэрийн 0.15 хувийг хамруулах ажлын бэлтгэл ажлыг хангана. /Геологийн судалгааны ажил гүйцэтгэх түүнд тавигдах шаардлага, зааврыг батлуулсан байна./ | - | Батлагдсан зааврын тоо | 0 | 1 | Геологийн судалгааны ажил гүйцэтгэх түүнд тавигдах шаардлага, зааврын төслийг боловсруулах ажлын хэсгийг Үндэсний геологийн албаны даргын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/27 дугаар тушаалаар байгуулсан.<br>"Геологийн нарийвчилсан болон сэдэвчилсэн зураглал, эрэл, эрэл-үнэлгээний ажлыг 1:25000, 1:10000 болон бусад нарийвчилсан масштабтайгаар зохиох, гүйцэтгэх, тайлагнах аргачилсан зөвлөмж, заавар" боловсруулах ажлыг гүйцэтгэсэн.<br>"Хархорин-25" 1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглал төслийг "Алсын хараа-2050"-д тусгагдсан Орхоны хөндийд шинэ нийслэлийн байршлыг сонгож, техник, эдийн засгийн үндэслэл, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, бүтээн байгуулахаар,<br>"Чойбалсан-25" 1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглал төслийг "Алсын хараа-2050"-д тусгагдсан "Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил"-ийн хүрээнд Зүүн бүсийн тулгуур хөгжлийн төвийн хүрээнд,<br>"Даланзадгад-25" 1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглал Өмнөд бүсийн тулгуур хөгжлийн төв, Уул уурхай, аж үйлдвэрлэл, үйлчилгээ, палеонтологийн аялал жуулчлалын бүсийн хүрээнд 2025 онд шинээр эхлүүлэхээр 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 1/249 дүгээр албан бичгээр Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд өгөх саналыг АҮЭБЯ-нд хүргүүлсэн.<br>*Хүрсэн түвшин: 2025 оны улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулахаар санал хүргүүлсэн.* | 70 | 50 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 1.3. Геохимийн 1:1000000-ын масштабын зураг зохиох ажлыг хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийг 100% хамруулах /ЗГҮАХ-АХТ 3.2.3.5/. | | | | | | | | | |
| 7 | 1.3.1 | Геохими-2019 төсөл. Монгол орны 1,149,529 км.кв нутаг дэвсгэрийг хамарсан 1:1000000-ын масштабын бүх элементийн тархалтын зураг, дагалдах тайлбар бичиг, мэдээллийн сан бүхий тайлангийн үр дүнг хүлээн авч, Монгол Улсын эрдэс баялгийн мэдээллийн санд бүртгүүлнэ. | - | Монгол Улсын нутаг дэвсгэрийг геологийн судалгааны ажлаар нэмэгдүүлсэн % /Тайлан ЭБМЗ-ийн хурлаар хамгаалагдсан байна/. | 26.5% | 100% | Монгол Улсын нутаг дэвсгэрт 1:1000000-ын масштабын бүх элементийн тархалтын зураг, дагалдах тайлбар бичиг, мэдээллийн сан бүрдүүлэх “Геохими-2019” үр дүнгийн тайланг Улсын төсвийн хөрөнгөөр 2024 оны 05 дугаар хурлаар оруулан хэлэлцүүлсэн. *Хүрсэн түвшин: Төлөвлөсний дагуу Монгол орны нутаг дэвсгэрийг 100 хувь бүрэн хамруулж тайланг Монгол Улсын эрдэс баялгийн мэдээллийн санд бүртгүүлсэн.* | 100 | 100 |
| Зорилт 1.4. Улсын төсвийн хөрөнгөөр явуулж байгаа үйл ажиллагааг эрхлэх, гэрээгээр гүйцэтгүүлсэн ажилд хяналт тавих, тайланг хүлээн авч хянах, холбогдох дүгнэлт гаргах замаар геологи судалгааны ажлыг удирдан чиглүүлэх /ҮГАСТ.Зорилт-1.2./. | | | | | | | | | |
| 8 | 1.4.1 | Сэдэвчилсэн судалгааны төслүүдийн 2024 оны төлөвлөгөө, төсвийг хянан, баталгаажуулна: Гео-Орчин-2022, Ханбогдын дүүрэгт 2023-2024 онд гүйцэтгэх геохимийн эрлийн ажил, Ханбогдын дүүрэгт 2023-2024 онд гүйцэтгэх соронзон судалгааны ажил. | - | ЭБМЗ-ийн хурлаар төсвийн тодотголыг хэлэлцүүлсэн төслийн тоо | 0 | 3 | Сэдэвчилсэн судалгааны Гео-Орчин-2022, Ханбогд дүүрэгт 2023-2024 онд гүйцэтгэх геохимийн эрлийн ажил, Ханбогдын дүүрэгт 2023-2024 онд гүйцэтгэх соронзон судалгааны төслүүдийн 2024 оны төлөвлөгөө, төсвийг хянаж, ЭБМЗ-ийн Улсын төсвийн хөрөнгөөр 2024 оны 03 дугаар хурлаар оруулж, 3 төсвийн тодотголыг хэлэлцүүлж, хурлын тэмдэглэл, дүгнэлтийг баталгаажуулсан. *Хүрсэн түвшин: 3 төслийн 2024 оны ажлын тоо хэмжээ, арга аргачлал, төлөвлөгөө баталж, төсвийг 2,431,397,423 төгрөгөөр батлуулж, АҮЭБЯ-нд 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 1/305 дугаар албан бичгээр цаг хугацаанд нь хүргүүлсэн.* | 100 | 100 |
| 9 | 1.4.2 | Сэдэвчилсэн судалгааны төслүүдийн 4 төслийн 2024 оны геологийн судалгааны ажлын гүйцэтгэлийг хянаж, үр дүнг хүлээн авч, төсвийг баталгаажуулна: Гео-Орчин-2022, Ханбогдын дүүрэгт 2023-2024 онд гүйцэтгэх геохимийн эрлийн ажил, Ханбогдын дүүрэгт 2023-2024 онд гүйцэтгэх соронзон | - | Хээрийн материал хүлээн авсан төслийн тоо | 0 | 4 | Сэдэвчилсэн судалгааны 1.“Гео-Орчин-2022” төсөлд 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр, 2.“Ханбогдын дүүрэгт 2023-2024 онд гүйцэтгэх геохимийн эрлийн ажил” төсөлд 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр, 3.“Ханбогдын дүүрэгт 2023-2024 онд гүйцэтгэх соронзон судалгааны ажил” төсөлд 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр, 4.“Агаарын геофизик-2024” төсөлд 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрүүдэд 2024 онд | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | судалгааны ажил, Агаарын геофизик-2024. | | | | | гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээ, үр дүнд, чанар, хэрэгжилтэд хяналт хийсэн. *Хүрсэн түвшин: 4 төслийн хээрийн материалыг төлөвлөгөөт хугацаанд нийт 17,538,644,459 төгрөгийн ажил гүйцэтгэлийг хүлээн авсан.* | | |
| Зорилт 1.5. Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрэн зургийг нэгтгэж дуусгах, нутаг дэвсгэрийн 100 хувийг хамруулах. /ЗГҮАХ-АХТ 3.2.3.3/. | | | | | | | | | |
| 10 | 1.5.1 | УГЗ-200 L листийн хэмжээнд буюу Монгол орны 839481.26 км.кв талбайд геологи, ашигт малтмалын иж бүрдэл зургийг нэгтгэх төслийн үр дүнг хүлээн авч, Монгол Улсын эрдэс баялгийн мэдээллийн санд бүртгүүлнэ. | - | Монгол Улсын нутаг дэвсгэрийг геологийн судалгааны ажлаар нэмэгдүүлсэн % /Тайлан ЭБМЗ-ийн хурлаар хамгаалагдсан байна/. | 14.09% | 67.76% | "УГЗ-200-Л хавтгайн нэгтгэл" төсөлд 160 хавтгайн хэмжээнд 5 иж бүрдэл буюу төслийн хэмжээнд 770 зураг, түүний тайлбар бичиг, дагалдах мэдээллийн сан бүхий төслийн үр дүнгийн тайлангийн боловсруулалтын ажил дууссан. *Хүрсэн түвшин: Шинжээч болон Улсын геологийн зургийн редакцаар хянагдаж дуусч байна.* ***2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн тайлангийн шуурхай хяналт хийсэн ажлын хэсгээс төслийн геологийн даалгаврын хугацааг 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл сунгах шийдвэр гаргасан.*** | 90 | 70 |
| 11 | 1.5.2 | УГЗ-200 М листийн хэмжээнд буюу Монгол орны 504222.97 км.кв талбайнд геологи, ашигт малтмалын иж бүрдэл зургийг нэгтгэх төслийн тайлан боловсруулалтын чанар, үр дүн, ажлын даалгаврын биелэлтэд хяналт тавина. | - | Тайлангийн шуурхай хяналт хийсэн төслийн тоо | 0 | 1 | "Эрээн чулуу" ХХК-ийн хэрэгжүүлж байгаа УГЗ-200 М лист нэгтгэл төсөлд 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр үр дүнгийн тайлан боловсруулалтын чанар, үр дүн, ажлын даалгаврын биелэлтэд хяналт хийсэн. Ажлын хэсэг 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдөр хуралдсан ЭБМЗ-ийн УТХ/2024-01 салбар хуралдаанаар хэлэлцэгдсэн Дорнод Монгол-ҮII төслийн үр дүнг тайланд нэгтгэх шийдвэр гаргасан тул Төслийн геологийн даалгаврын үр дүнгийн тайлангийн эцсийн суурин боловсруулалтын хугацааг 3 сараар сунгах хүсэлтийг ҮГА хүлээн авч, 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/20 дугаар тушаал, шийдвэрийг гаргуулсан. *Хүрсэн түвшин: Холбогдох журам, гэрээнд заасны дагуу сунгах арга хэмжээг авсан.* | 100 | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | 1.5.3 | УГЗ-200 М листийн хэмжээнд буюу Монгол орны 504222.97 км.кв талбайнд геологи, ашигт малтмалын иж бүрдэл зургийг нэгтгэх төслийн үр дүнг хүлээн авч, Монгол Улсын эрдэс баялгийн мэдээллийн санд бүртгүүлнэ. | - | Монгол Улсын нутаг дэвсгэрийг геологийн судалгааны ажлаар хамруулсан % /Тайлан ЭБМЗ-ийн хурлаар хамгаалагдсан байна/. | 67,76% | 100% | УГЗ-200 М лист нэгтгэл төслийн үр дүнгийн тайлан бичвэрт хүлээгдэж байсан Дорнод Монгол-YII төслийн үр дүнг нэгтгэн оруулж төслийн үр дүнгийн тайлан бичвэр зохиогдож, УГЗ-ийн редакцын зөвлөлөөр хянагдаж дүгнэлт гарсан. Шинжээч томилох хүсэлтийн ЭБМЗ-д цахим системээр гаргасан боловч АҮЭУЯ-ны бүтэц ЭБМЗ-ийн бүрэлдэхүүний өөрчлөлт, цахим системд хийгдэж байгаа шинэчлэлтийн улмаас биднээс үл хамаарах шалтгаанаар хүлээлтийн байдалтай байна. АҮЭБЯ-наас хариу хүлээгдэж байна. | 90 | 70 |
| 13 | 1.5.4 | Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зураг зохиох “УГЗ-200-Д-VII” төслийн үр дүнг хүлээн авч, Монгол Улсын эрдэс баялгийн мэдээллийн санд бүртгүүлнэ. | - | Монгол Улсын нутаг дэвсгэрийг геологийн судалгааны ажлаар хамруулсан % /Тайлан ЭБМЗ-ийн хурлаар хамгаалагдсан байна/. | 96.22% | 100% | Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зураг зохиох “УГЗ-200-Д-VII” төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн УТХ-2024-05 дугаар хурлаар оруулан хэлэлцүүлж хамгаалагдсан. *Хүрсэн түвшин: УГЗ-200 зургаар Монгол улсын нутаг дэвсгэрийг 100% хамруулсан. АҮЭБС-ын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/72 дугаар тушаалаар Монгол Улсын эрдэс баялгийн мэдээллийн санд бүртгүүлсэн.* | 100 | 100 |
| Зорилт 1.6. Агаарын геофизикийн 1:200000-ны масштабын соронзон судалгааны ажлыг хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийн 70 хувийг хамруулах /ЗГҮАХ-АХТ 3.2.3.4/. | | | | | | | | | |
| 14 | 1.6.1 | Баруун Монголд 104044 км.кв талбайнд гүйцэтгэсэн Агаарын геофизикийн цогцолбор судалгааны "Ховд-1" төслийн үр дүнг хүлээн авч, Монгол Улсын эрдэс баялгийн мэдээллийн санд бүртгүүлнэ. | - | Монгол Улсын нутаг дэвсгэрийг геологийн судалгааны ажлаар нэмэгдүүлсэн % /Тайлан ЭБМЗ-ийн хурлаар хамгаалагдсан байна/. | 60% | 66.6% | Агаарын геофизикийн таван сувгийн цогцолбор судалгааны "Ховд-1" төслийн үр дүнг хүлээн авч, ЭБМЗ-ийн УТХ-2024-04 дүгээр хурлаар оруулан хэлэлцүүлж хамгаалагдсан. *Хүрсэн түвшин: Монгол орны нутаг дэвсгэрийн 66.6% хамруулсан. АҮЭБС-ын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/64 дүгээр тушаалаар Монгол Улсын эрдэс баялгийн мэдээллийн санд бүртгүүлсэн.* | 100 | 100 |
| 15 | 1.6.2 | Монгол Улсын нутаг дэвсгэрийн 15.52%-ийг хамран хэрэгжих Агаарын геофизикийн цогцолбор судалгааны "Агаарын геофизики-2024" төслийн тендер | - | Монгол Улсын нутаг дэвсгэрийг геологийн судалгааны | 66.6% | 74.36% | Агаарын геофизикийн цогцолбор судалгааны "Агаарын геофизик-2024" төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулж, шалгарсан “Геологийн судалгаа-шинжилгээний төв” ТӨҮГ-тай 2024 оны 05 дугаар сарын 08-ны | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | шалгаруулалтыг зохион байгуулж, гэрээг байгуулж төслийн ажлыг эхлүүлнэ. | | ажлаар нэмэгдүүлсэн %. | | | өдөр геологийн судалгааны ажил гүйцэтгэх гэрээг байгуулж, төслийн ажлыг шинээр эхлүүлсэн.<br>Төслийн хүрээнд 2024 онд Агаарын геофизикийн "Tempest" цахилгаан соронзон болон нэмэлтээр нэгэн зэрэг хэмжих багажууд болох Scintrex CS-3 соронзон орны, RS радиометрийн, iCORUS хүндийн хүчний төхөөрөмжүүдээр 67829 км$^2$ талбайн геофизикийн цогц системээр хэмжилт, боловсруулалтын ажлыг гүйцэтгэсэн.<br>*Хүрсэн түвшин: "Агаарын геофизики-2024" төслийн гэрээг байгуулж төслийн ажлыг эхлүүлэн 2024 онд хийгдсэн нислэгээр нийт нутаг дэвсгэрийн 4.34 хувийг хамруулаад байна.* | | |
| Зорилт 1.7. Бүс нутаг болон хотуудын геоэкологи, гидрогеологи, геотермийн судалгааны ажил хийх. /ЗГҮАХ-АХТ 3.2.3.6/. | | | | | | | | | |
| 16 | 1.7.1 | Дархан хот, Ховд хотын нутаг дэвсгэрт 1:25000-ны масштабын геоэкологи, гидрогеологийн зураглал, дагалдах мэдээллийн сан бүхий тайлангийн үр дүнг хүлээн авч, Монгол Улсын эрдэс баялгийн мэдээллийн санд бүртгүүлнэ. | - | ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн төслийн тоо | 0 | 2 | 1. Ховд хотын нутаг дэвсгэрт 1:25000-ны масштабын геоэкологи, гидрогеологийн зураглал, дагалдах мэдээллийн сан бүхий үр дүнгийн тайланг хүлээн авч, ЭБМЗ-ийн УТХ-2024-05 дугаар хурлаар хэлэлцүүлж, хамгаалагдсан. АҮЭБС-ын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/63 дугаар тушаалаар Монгол Улсын эрдэс баялгийн мэдээллийн санд бүртгүүлсэн.<br>2. Дархан хотын нутаг дэвсгэрт 1:25000-ны масштабын геоэкологи, гидрогеологийн зураглал, дагалдах мэдээллийн сан бүхий үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн УТХ-2024-08 дугаар хурлаар оруулж хэлэлцүүлсэн.<br>Хурлаас үр дүнгийн тайланд засвар оруулах шийдвэр гарсан.<br>*Хүрсэн түвшин: Засвар хийгдсэн төслүүдийг хэлэлцүүлэх ЭБМЗ-ийн хурал 2024 оны 12 дугаар сарын 20-нд товлогдсон.* | 100 | 70 |
| 17 | 1.7.2 | Монгол Улсын төв болон хойд хэсгийн 602984,0 км.кв талбайд гүний хагарал, түүнтэй холбоотой үүссэн булаг рашааны судалгааны "Гүний хагарал-1" төслийн үр дүнг хүлээн авч, улсын эрдэс баялгийн мэдээллийн санд бүртгүүлнэ. | - | ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн төслийн тоо | 0 | 1 | "Гүний хагарал-1" төслийн ажлын үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн УТХ-07 дугаар хурлаар оруулж, үр дүнг хүлээн авсан.<br>*Хүрсэн түвшин: Тус төслийн ажил онц сайн үнэлгээтэй хамгаалагдсан. АҮЭБС-ын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/70 дугаар* | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | *тушаалаар Монгол Улсын эрдэс баялгийн мэдээллийн санд бүртгүүлсэн.* | | |
| 18 | 1.7.3 | Монгол Улсын босоо тэнхлэгийн шугаман байгууламжийн дагуух бүс нутгийн геологийн орчны “Гео-Орчин-2022” төслийн тайлан боловсруулалтын чанар, үр дүн, ажлын даалгаврын биелэлтэд хяналт хийнэ. | - | Тайлангийн шуурхай хяналт хийсэн төслийн тоо | 0 | 1 | “Гео-Орчин-2022” төслийн тайлан боловсруулалтын явцад шуурхай хяналтын ажлыг 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдөр хийсэн.<br>*Хүрсэн түвшин: Үр дүнгийн тайлангийн чанар, үр дүн, ажлын даалгаврын биелэлтэд хяналт хийж, зөвлөмж өгсөн.* | 100 | 70 |
| Зорилт 1.8 Геологийн өв, тулгуур зүсэлт, онцлог тогтоц, тектоник, минерагенийн болон геохими, геофизик, энергийн түүхий эдийн хэтийн төлөвийн сэдэвчилсэн судалгааны ажил хийх /ЗГҮАХ-АХТ 3.2.3.7/. | | | | | | | | | |
| 19 | 1.8.1 | Монгол орны нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд Мезо-Кайнозойн хурдсын тархалт, зүй тогтол, ашигт малтмалын хэтийн төлөвийн үнэлгээ өгөх “Мезо-Кайнозой-2021” төслийн үр дүнг хүлээн авч, Монгол Улсын эрдэс баялгийн мэдээллийн санд бүртгүүлнэ. | - | Монгол Улсын нутаг дэвсгэрийг геологийн судалгааны ажлаар хамруулсан % /Тайлан ЭБМЗ-ийн хурлаар хамгаалагдсан байна/. | 0 | 100 | “Мезо-Кайнозой-2021” төслийн тайлангийн явцад шуурхай хяналт хийсэн ажлын хэсгийн шийдвэрийг үндэслэн геологийн даалгаврын үр дүнгийн тайлангийн эцсийн суурин боловсруулалтын хугацааг ҮГА-ны даргын 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А/33 тоот тушаалаар 6 сарын хугацаагаар сунгасан.<br>*Хүрсэн түвшин: Тухайн төсөл нь 6 сарын дотор геологийн даалгаврыг хийж гүйцэтгэх гэрээг албан ёсоор байгуулсан бөгөөд ҮГА гэрээний дагуу ажиллах юм.* | 70 | 50 |
| 20 | 1.8.2 | “Ханбогдын дүүрэгт 2023-2024 онд гүйцэтгэх геохимийн эрлийн ажил” төслийн хээрийн үйлдвэрлэлийн ажлын хэрэгжилтийг хангаж, хяналт тавина. | - | Хээрийн шуурхай хяналт хийсэн төслийн тоо | 0 | 1 | “Ханбогдын дүүрэгт 2023-2024 онд гүйцэтгэх геохимийн эрлийн ажил” төсөлд 2024 оны 06 дугаар сарын 25, 26-ны өдрүүдэд 2024 оны хээрийн үйлдвэрлэлийн ажил, завсрын суурин боловсруулалт, сар бүрийн ирүүлсэн гүйцэтгэлийг газар дээр нь баталгаажуулсан.<br>*Хүрсэн түвшин: Гүйцэтгэлийг газар дээр нь баталгаажуулсан ба хэмжилт, хяналтын ажил бүрэн хийгдсэн.* | 100 | 100 |
| 21 | 1.8.3 | “Ханбогдын дүүрэгт 2023-2024 онд гүйцэтгэх соронзон судалгааны ажил” төслийн хээрийн үйлдвэрлэлийн ажлын хэрэгжилтийг хангаж, хяналт тавина. | - | Хээрийн шуурхай хяналт хийсэн төслийн тоо | 0 | 1 | “Ханбогдын дүүрэгт 2023-2024 онд гүйцэтгэх соронзон судалгааны ажил” төсөлд 2024 оны 06 дугаар сарын 24, 25-ны өдрүүдэд 2024 оны хээрийн үйлдвэрлэлийн ажил, завсрын суурин боловсруулалт, сар бүрийн ирүүлсэн гүйцэтгэлийг газар дээр нь баталгаажуулсан.<br>*Хүрсэн түвшин: Гүйцэтгэлийг газар дээр нь баталгаажуулсан ба хэмжилт, хяналтын ажил бүрэн хийгдсэн.* | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **ЗОРИЛГО 2. Ашигт малтмалын тархалтын зүй тогтол, минерагений суурь судалгаа хийж, эрдэс баялгийн хэтийн төлөвийн үнэлгээ өгөх, улс орны эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ашигт малтмалын эрлийн болон хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахуйц бүс, зангилгаа, талбайг ялгах ажлыг зохион байгуулах** | | | | | | | | | |
| Зорилт 2.1. Өндөр технологийн түүхий эд болох газрын ховор элемент, үнэт, өнгөт, хар, холимог металл, металл бус ашигт малтмал болон газрын тосны эрэл,хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эрдэс баялгийн нөөцийг арвижуулах /Шинэ сэргээлтийн бодлого-3.1.2, ЗГҮАХ-3.2.5/. | | | | | | | | | |
| 22 | 2.1.1 | Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа ӨТТЭ-2, БМШАМ, ЭҮ-4 эрдэс баялгийн сэдэвчилсэн судалгаа төслүүдийн үр дүнг хүлээн авч, Монгол улсын эрдэс баялгийн мэдээллийн санд бүртгүүлнэ. | | ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн төслийн тоо | 0 | 3 | -ӨТТЭ-2-2022, БМШАМ-2022, ЭҮ-4-2022 төслүүдийн тайлангийн шуурхай хяналтыг 2 удаа хийсэн.<br>-Үр дүнгийн тайлангийн эцсийн суурин боловсруулалтын хугацааг сунгуулахаар ирүүлсэн албан бичиг болон тайлангийн шуурхай хяналт хийсэн хурлын тэмдэглэлийг үндэслэн ажилласан.<br>*Хүрсэн түвшин: Албаны даргын тушаалаар "ӨТТЭ-2-2022" ба "ЭҮ-4-2022" төслийг 2 сараар, "БМШАМ-2022" төслийг 3 сараар тайлангийн эцсийн суурин боловсруулалтын хугацааг сунгасан.* | 90 | 70 |
| 23 | 2.1.2 | Улсын төсвийн хөрөнгө /УТХ/-өөр хэрэгжиж байгаа эрдэс баялгийн сэдэвчилсэн судалгаа /ЭБСС/-ны төслүүдийн хээрийн үйлдвэрлэлийн болон суурин боловсруулалтын ажлын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавина (ӨТТЭ-2, БМШАМ, ЭҮ-4, Мета алт-2022). | | Хяналт хийсэн төслийн тоо | 0 | 4 | -Төслүүдийн 2024 оны төсвийн тодотголыг хянаж, ЭБМЗ-ийн 03 дугаар сарын 05, 06-ны өдрүүдийн хуралдаанаар хэлэлцэж, зөвлөлийн дүгнэлт гарч албажсан.<br>-Албаны даргын 2024 оны 04 дүгээр сарын 09-ний болон 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр баталсан "Тайлангийн шуурхай (явцын) хяналт хийх удирдамж"-ийн хүрээнд "Судалт Мана" ХХК болон МУИС-ийн түншлэлийн хэрэгжүүлж байгаа "БМШАМ-2022", "Геологийн судалгаа-шинжилгээний төв" ТӨҮГ-ын хэрэгжүүлж байгаа "ЭҮ-4-2022", "Демонг инженеринг" ХХК-ийн хэрэгжүүлж байгаа "ӨТТЭ-2-2022" төслүүдийн тайлангийн шуурхай хяналт 2 удаа хийсэн.<br>*Хүрсэн түвшин: Албаны даргын 2024 оны 10 дугаар сарын 25-ны А/61 дүгээр тушаалаар байгуулагдсан Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд гүйцэтгэсэн геологийн судалгааны төслүүдийн хээрийн материал хүлээн авах болон тайлангийн шуурхай хяналт хийх Ажлын хэсгийн хүрээнд "БМШАМ-2022", "ЭҮ-* | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | *4-2022", "ӨТТЭ-2-2022", "Мета алт-2022" төслийн хээрийн материалыг хүлээн авсан.* | | |
| 24 | 2.1.3 | /УТХ/-өөр хэрэгжиж байгаа ӨТТЭ-1, ЭҮ-2, ЭҮ-3, ГАСАМ эрдэс баялгийн сэдэвчилсэн судалгаа төслүүдийн үр дүнг хүлээн авч, Монгол улсын эрдэс баялгийн мэдээллийн санд бүртгүүлнэ. | - | ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн төслийн тоо | 0 | 4 | -"Геосигналс" ХХК-ийн гүйцэтгэсэн "Эрэл Үнэлгээ-3-2022", "Меланжсурвей" ХХК-ийн гүйцэтгэсэн "Эрэл Үнэлгээ-2-2021", "Геологийн судалгаа-шинжилгээний төв" ТӨҮГ-ын гүйцэтгэсэн "ӨТТЭ-1-2021" болон "Мянганы хас" ХХК-ийн гүйцэтгэсэн "ГАСАМ" төслүүдийн үр дүнгийн тайланг хянаж, холбогдох засварыг хийлгэсэн.<br>*Хүрсэн түвшин: 2024 оны 06 дугаар сарын 06-наас 2024 оны 06 дугаар сарын 07-нд хуралдсан.*<br>*Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэгдэж, үр дүнгийн тайлангуудыг хүлээн авсан.* | 100 | 100 |
| Зорилт 2.2. Улсын төсвийн хөрөнгөөр явуулж байгаа үйл ажиллагааг эрхлэх, гэрээгээр гүйцэтгүүлсэн ажилд хяналт тавих, тайланг хүлээн авч хянах, холбогдох дүгнэлт гаргах замаар геологийн судалгааны ажлыг удирдан чиглүүлэх /ЗГҮАХ-АХТ 3.2.3/ | | | | | | | | | |
| 25 | 2.2.1 | Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны төслүүдийн гэрээ дүгнэх актын төслийг (ӨТТЭ-1, ЭҮ-2, ЭҮ-3, Төв ази 3D 5-р үе шат) боловсруулж, АҮЭБЯ-нд хүргүүлнэ. | - | Гэрээ дүгнэсэн төслийн тоо | 0 | 15 | - "ӨТТЭ-1", "ЭҮ-2", "ЭҮ-3", "Төв ази 3D 5-р үе шат" төслүүдийн үр дүнгийн тайлан ЭБМЗ-өөр хамгаалагдсан.<br>*Хүрсэн түвшин: Гэрээ дүгнэх актын 2 төслийг ("ЭҮ-1-2020", "БӨМ-Алт-2019") боловсруулж, АҮЭБЯ-нд хүргүүлсэн.* | 100 | 100 |
| Зорилт 2.3. Улсын төсвийн хөрөнгөөр геологи-хайгуулын ажил хийгдсэн ордыг ашиглаж байгаа хуулийн этгээдээс АМТХ-д заасан зардлыг төсөвт төвлөрүүлэхэд шаардлагатай тооцоо хийх | | | | | | | | | |
| 26 | 2.3.1 | УТХ-өөр ГХ-ын ажил хийж, нөөцийг тогтоон улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн ордоос олборлолт явуулж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчээс геологи-хайгуулын ажилд Улсын төсвөөс зарцуулсан зардлыг тооцон, холбогдох төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ. | - | Хүргүүлсэн мэдээний тоо | 0 | 40 | Ашигт малтмал газрын тосны газраас нөхөн төлбөрийн тооцоо хийлгэхээр манай байгууллагад ирүүлээгүй.<br>/ҮГА-наас холбогдох ажлыг нэхсэн болно/. | - Гүйцэтгэл гаргах боломжгүй, Үнэлэх боломжгүй | - |
| **ЗОРИЛГО 3. Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн төрөлжсөн, нэгдсэн сан бүрдүүлэх, баяжуулах, боловсруулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах** | | | | | | | | | |
| Зорилт 3.1.Хэрэглэгчийг мэдээллээр түргэн шуурхай найдвартай хангах зорилгоор Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн нэгдсэн цахим санг баяжуулах /ЗГҮАХ 3.2.4/. | | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 27 | 3.1.1 | Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн нэгдсэн цахим санг /ҮГЭБМНЦС/ баяжуулах. | - | 113.3.Баяжуулсан мэдээллийн тоо | 0 | 1000 | Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн нэгдсэн цахим санг улсын төсвөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлуудын /Геологийн баримтын төв архивд хадгалагдаж байгаа/ үр дүнгийн тайлангаас Илрэл-5418, Уст цэг-8200, Цооног-5600, Шлихийн хүрээ-2966, Өрөмдсөн цооног-1300, эрдэсжсэн цэг-201, Хагарлын м/с-2350. *Хүрсэн түвшин: Нийт **11245** ширхэг мэдээллээр баяжуулсан.* | 100 | 100 |
| 28 | 3.1.2 | Геологийн онцлог тогтцын суурь мэдээллийн санг баяжуулж, цахим бүтээлийн сан үүсгэнэ. | - | Баяжуулсан болон цахимжуулсан мэдээллийн тоо | 0 | 500 | Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн нэгдсэн цахим санг хөгжүүлэх зорилгоор Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа "Геологийн баримт-1" төслийн ажлын хүрээнд вэб сайтын хэсэгт **5833** нийтлэл, МонГеоКат системд метадата 4880 ширхгийг оруулсан. *Хүрсэн түвшин: Цахим санг нийт **10713** өгөгдлөөр баяжуулсан.* | 100 | 100 |
| 29 | 3.1.3 | Геологийн чулуун дээжийн сан болон цахим архивыг баяжуулна. | - | Баяжуулсан мэдээллийн тоо | 0 | 608 | Цахим архивыг баяжуулах ажлаар Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй Цахим архив-1, Чулуун дээжийн сан-1 төслүүдийн гүйцэтгэлийн хүрээнд eDOC архивын программд **277** тайлангийн 1122 хадгаламжийн нэгжийн **27432** хуудас, **6649** зураг оруулж мэдээллээр баяжуулсан. *Хүрсэн түвшин: Нийт **13282** файлыг хөрвүүлэн мэдээллийг баяжуулсан.* *Системд Чулуун дээж-1039, Шлиф-2893, Аншлиф-330 өгөгдөл оруулсан. Цахим санг нийт **4262** мэдээллээр баяжуулсан байна.* | 100 | 100 |
| Зорилт 3.2. Хэрэглэгчийг мэдээллээр шуурхай, найдвартай хангах геологийн төрөл бүрийн мэдээллээр төрөлжсөн нэгдсэн цахим сан бүрдүүлэх, баяжуулах, боловсруулах /ЗГҮАХ 3.2.4/. | | | | | | | | | |
| 30 | 3.2.1 | Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн төрөл бүрийн судалгааны ажлын үр дүнд зохиосон геологийн зургийг хүлээн авч, цахим санг шинээр бүрдүүлэх, баяжуулах, | - | Хүлээж авсан тайлангийн тоо | 0 | 3 | Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй үр дүнгийн тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хамгаалсан.<br>1. УГЗ-200 D-VII,<br>2. Дөч гол-50,<br>3. Улаанбаатар геоэкологи | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | боловсруулах, хэрэглэгчийг мэдээллээр хангана. | | | | | 4. Асгат уул-50 зэрэг 4 тайлангийн тоон мэдээллийг шалган хүлээн авсан.<br>*Хүрсэн түвшин: Цахим санг шинээр бүрдүүлсэн.* | | |
| 31 | 3.2.2 | Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн төрөл бүрийн масштабын геофизикийн судалгааны үр дүнгээр цахим сан шинээр бүрдүүлэх, баяжуулах, тэдгээрийг боловсруулж, хэрэглэгчийг мэдээллээр хангана. | - | Боловсруулсан тайлангийн тоо | 0 | 10 | Геологийн баримтын төв архивт хадгалагдаж байгаа 5680, 6635, 5781, 5624, 8455, 7940, 9950, 10155, 10065 дугаартай 9 тайлангийн үр дүнгийн зургуудаас эрлийн 17 талбайн геофизикийн зургийг боловсруулсан.<br>*Хүрсэн түвшин: Цахим санг баяжуулсан.* | 100 | 100 |
| 32 | 3.2.3 | Ашигт малтмалын орд, нөөцийн улсын тоо бүртгэл хөтөлж хэрэглэгчийг нууцад хамааруулснаас бусад мэдээллээр хангана. | - | Хөтлөлт хийсэн ордын тоо | 0 | 100 | Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн гаргасан дүгнэлтийг үндэслэн Үндэсний Геологийн Албаны даргын тушаалын дагуу 76 ордын нөөцийн давхцалыг хянан, холбогдох шийдвэрийн төслийг боловсруулсан.<br>Ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд шинээр *10321, 10323, 10329, 10331, 10332, 10333, 10335, 10336, 10347, 10349, 10362, 10374, 10379, 10388, 10386, 10387, 10389, 10417, 10422, 10429, 10437, 10454, 10711, 10713, 10715, 10722, 10728, 10729, 10736, 10743, 10745, 10755, 10757, 10759, 6402, 9999, 10444, 10445, 10447, 10448, 10449, 10450, 10740, 10741, 10751, 10753, 10758, 10760, 10761, 10762, 10763, 10775, 8554, 9274, 9407, 9445, 10163, 10266* дугаар бүхий хайгуулын тайлангийн үр дүнг нэмж бүртгэсэн.<br>*Хүрсэн түвшин: Геологийн баримтын төв архивд тушаагдсан 65 нөөцийн мэдээллийг бүртгэв.* | 100 | 70 |
| 33 | 3.2.4 | Шинээр тогтоогдсон илрэлийн мэдээллээр нэгдсэн цахим санг баяжуулна. | - | Баяжуулсан илрэлийн тоо | 0 | 20 | Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлаар тогтоогдсон илрэлүүдийг Ашигт малтмалын илрэлийн санд бүртгэгдсэн илрэлүүдийн давхцалыг шалгасан. | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | *Хүрсэн түвшин: Шинээр 22 илрэлийг мэдээллийн санд бүртгэсэн. 9 илрэлийн мэдээлэлд нэмэлт баяжуулалт хийсэн.* | | |
| Зорилт 3.3. Төрийн цахим ой санамж болох мэдээллийн сан, өгөгдлийн бүрэн бүтэн, нэгдмэл, аюулгүй байдлыг хангаж нэг эх сурвалж бүхий мэдээлэл, нээлттэй өгөгдлийг бий болгон хөгжүүлж, төрийн үйлчилгээний нэгдсэн системтэй холбох, төрийн үйлчилгээг түргэн шуурхай болгох /2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 5.3/. | | | | | | | | | |
| 34 | 3.3.1 | Мэдээллийн аюулгүй байдал, сүлжээ, удирдлагын төхөөрөмжүүдийн найдвартай ажиллагааг хангана. | - | 4.Хангасан эсэх:<br>0-үгүй<br>1-тийм | 0 | 1 | Мэдээллийн системийн үндсэн төхөөрөмжүүдийн (физик сервер, дамжуулах болон хадгалах, нөөцлөх, хамгаалах) техник хангамжийн ашиглалт үйлчилгээг тогтмол хийж хэвийн ажиллагааг хангаж ажилласан.<br>Серверийн өрөөний үл тасалдах цахилгаан тэжээл (UPS 3PH 10 KVA), хөргөлтийн (AirCondition 0N-9580AC) төхөөрөмжийн ажиллагаанд хяналт тавьж серверүүдийн хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажилласан.<br>Мэдээллийн системийн виртуал серверүүдийн үйлдлийн системийн хэвийн ажиллагаа хангаж windows үйлдлийн системийн сар бүрийн 12 удаагийн Cumulative Update for Windows Server шинэчлэлтүүдийг бүх серверүүдэд тогтмол хийсэн.<br>Үндэсний Геологийн албаны сүлжээний хамгаалалтын PaloAlto PA820 (sn: 012001051507, 012001051070) төхөөрөмжүүдийн PAN-OS үйлдлийн системийн шинэчлэлтийг зургаан удаагийн давталтаар 10.2.7 - 10.2.12-h1, Геологийн баримтын төв архивын сүлжээний хамгаалалтын PaloAlto PA440 (Sr - 021201083609) төхөөрөмжийн PAN-OS үйлдлийн системийн хувилбарыг зургаан удаагийн давталтаар 10.2.7 - 11.2.4 болгон шинэчилсэн. Хамгаалалтын болон удирдлагын тохируулгыг тухай бүрт хийж сүлжээний хэвийн ажиллагаа хангаж ажилласан.<br>Вирусийн эсрэг болон сүлжээний хамгаалалтын хяналтыг тогтмол хийж эрсдэлээс хамгаалах, удирдлагын Kaspersky | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Security Center программын хувилбарыг 14.0.0.10902 - с 15.1.0.20748, Ms Windows үйлдлийн системтэй 20 виртуал серверийн вирусын эсрэг хамгаалалтын Kaspersky Security 11 for Windows Server программын хувилбарыг 10.1.2.996 -с 11.0.1.897, Kaspersky Endpoint Security программын хувилбарыг KES-12.3.0.493-с 12.7.0.533, Network Agent хувилбарыг 12.2.0.4376-с 15.1.0.20748 болгож шинэчлэсэн ба хэрэглэгчийн компьютерийн хамгаалалтын хяналт үйлчилгээг тогтмол хийсэн.<br>Байгууллагын хяналтын камерын хэвийн ажиллагааг хангаж ажилласан. Ажиллагаагүй болсон 3 дугаар давхрын хяналтын камерыг сольсон.<br>Мэдээллийн технологийн зүгээс ажилтан албан хаагчдын ажил үүргээ хэвийн явуулах нөхцөлөөр хангаж 38 компьютерт программ хангамжийн болон техник хангамжийн засвар, бусад төхөөрмжүүдийн тохируулгыг хийсэн.<br>АРВИС Системс ХХК-тай 24/21 тоот гэрээ байгуулж серверийн өрөөний Schneider Electric AirCondition SUAV 0332a загварын хөргөлтийн систем, хоёр ширхэг Schneider Electric Easy UPS 3S 10kVA загварын үл тасалдах тэжээл нөөцлөгчүүд, батарей, дагалдах автомат хэрэгслэлүүдэд техникийн бүрэн үзлэг, шалгалтыг хийлгэж шаардлагатай үйлчилгээг хийлгэсэн.<br>*Хүрсэн түвшин: Мэдээллийн аюулгүй байдлыг бүрэн хангасан.* | | |
| 35 | 3.3.2 | Мэдээллийн сан, өгөгдлийн нэгдмэл байдлыг хангаж, төрийн үйлчилгээг нэгдсэн системд холбоно. | - | 0-холбогдоогүй<br>1-холбогдсон | 0 | 1 | 1. Улсын геологийн зургийн редакцын журам шинэчлэгдэн батлагдсантай холбоотой бүх зөвлөх ба гишүүдийн дэлгэрэнгүй мэдээллийг веб сайтад оруулж нийтэлсэн. Мөн улсын зургийн редакцаас зөвлөмж авах формыг хийж бөглөсөн мэдээлэл uzr@ngs.gov.mn хаяг руу илгээгдэхээр тохируулан веб сайтад нийтэлсэн.<br>2. Албаны веб сайтын | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | (ngs.gov.mn) нэмэлт (plugin) уудыг (17) шинэчилж сайтын тогтвортой үйл ажиллагааг сайжруулж веб хуудас дуудах хурдыг сайжруулсан. Мөн Мэдээллийн сан бүрдүүлэх зааврыг нэмж байгууллагын бүтэц хэсгийн мэдээллийг шинэчилсэн.<br>*Хүрсэн түвшин: Үндэсний геологийн албаны ngs.gov.mn сайт болон сошиал хуудсанд 2024 он гарснаас хойш нийт 40 төрлийн мэдээ мэдээллийг нийтэлсэн.* | | |
| Зорилт 3.4. Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд гүйцэтгэсэн геологийн болон сэдэвчилсэн судалгааны ажлын үр дүнгээр тогтоогдсон, сонгон шалгаруулалтаар олгох боломжтой, ашигт малтмалын хэтийн төлөвтэй талбайн мэдээллийг нэгтгэж холбогдох төрийн захиргааны төв байгууллагыг мэдээллээр хангах | | | | | | | | | |
| 36 | 3.4.1 | Судалгааны ажлуудын үр дүнгээр хуулиар хориглосон, хязгаарласан талбайтай давхцалгүй ашигт малтмалын хуримтлал бүхий талбайг ялгаж мэдээллийг бэлтгэнэ. | - | Ялгасан талбайн тоо | 0 | 200 | Хуулиар хориглосон, хязгаарласан талбайтай давхцалгүй ашигт малтмалын хуримтлал бүхий **243** талбайг ялгаж сонгон шалгаруулалтын журмын дагуу Аж үйлдвэр, Эрдэс баялгийн яаманд хүргүүлсэн.<br>*Хүрсэн түвшин: Нийт ялгасан талбайн тоо 751.* | 100 | 100 |
| Зорилт 3.5. Монгол Улсын ашигт малтмалын ордын нөөцийн тэнцэл /баланс/ гаргах, тайлагнах, хөтлөх | | | | | | | | | |
| 37 | 3.5.1 | Ашигт малтмалын нөөцийн хөдөлгөөнийг бүртгэх, нөөцийн тэнцэл гаргана.<br>/Төмөр, Зэс, Мөнгө, Цайр, Хар тугалга, Лити, ГХЭ / | - | Тэнцэл гаргасан ашигт малтмалын төрөл | 0 | 11 | *Хүрсэн түвшин: Уран, Төмөр, Зэс, Мөнгө, Цайр, Хартугалга, Лити, ГХЭ, Ал тны үндсэн гэсэн 9 ашигт малтмалын төрлүүдээр нөөцийн хөдөлгөөнийг бүртгэж Улсын нөөцийн тэнцлийг гаргасан.* | 70 | 70 |
| **ЗОРИЛГО 4. Төрийн захиргааны төв байгууллагад геологийн судалгааны бодлого боловсруулахад мэдээлэл үзүүлэх, холбогдох төрийн захиргааны болон судалгааны байгууллагатай гидрогеологи, геофизик, геоэкологи, мөн түүнчлэн ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч, газрын тосны эрлийн, гэрээлэгчийн хайгуул, ашиглалтын талбайд хамаарах мэдээллээр улсын геологийн фонд, баримтын төрлийг арвижуулан, харилцан үйлчилгээ үзүүлэх.** | | | | | | | | | |
| Зорилт 4.1 Архивын баримтын аюулгүй байдлын баталгааг хангаж, хадгалалт хамгаалалтыг сайжруулах шат дараалсан арга хэмжээ авах /ҮГА-ны Стратеги төлөвлөгөө 4.1/ | | | | | | | | | |
| 38 | 4.1.1 | Геологийн архивын хадгаламжийн сангийн камержуулалтын бичлэг хадгалалтын хугацааг уртасгах, зориулалтын тоног төхөөрөмжийг сайжруулна. | - | Архивын хадгалам жийн санг камержуулсан эсэх<br>0-Үгүй<br>1-Тийм | 0 | 1 | Геологийн баримтын төв архивын үйлчилгээний өрөө, Тайлан хүлээн авах өрөө, Нөхөн бүрдүүлэлтийн хөмрөгийн өрөөнүүдэд 3 хяналтын камер байршуулсан.<br>*Хүрсэн түвшин: Хяналтын камер байршуулснаар архивын нийт 2 үйлчилгээний өрөө, 5 хадгаламжийн сан, үйлчилгээний уншлагын танхимын аюулгүй* | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | *ажиллагааг хянах, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах нөхцөл бүрдсэн.* | | |
| 39 | 4.1.2 | Геологи, уул уурхайн төрөлжсөн архивын барилгын зураг төсөл боловсруулах санхүүжилтийн саналыг холбогдох газарт хүргүүлнэ. | - | Санхүүжилтийг АҮЭБЯ-нд хүргүүлсэн тоо | 0 | 1 | Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх бодлого, төлөвлөгөөтэй уялдуулан 2025 оны төсвийн хязгаарын саналд төрөлжсөн архивын барилга барих санхүүжилтийн ерөнхий төсвийн саналыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд хүргүүлсэн.<br>2025 оны төсөвт төрөлжсөн архивын барилга барих санхүүжилтийн ерөнхий төсвийн саналыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Сангийн яаманд хүргүүлсэн бөгөөд энэхүү барилга барих төслийн ажлын санхүүжилт хүлээгдэж байна.<br>*Хүрсэн түвшин: Төслийн хүрээнд санхүүжигдэх боломжгүй байгаа ба Үндэсний геологийн албанаас хамаарахгүй байна.* | 100 | 100 |
| 40 | 4.1.3 | Стандартын шаардлага хангасан шинэ цогцолбор барилга барих төслийн ажлыг эхлүүлэх саналыг АҮЭБЯ-нд хүргүүлнэ. | | Төслийн саналыг АҮЭБЯ-нд хүргүүлсэн эсэх:<br>0-Үгүй<br>1-Тийм | 0 | 1 | Архивын 2 албан хаагч Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын төрөлжсөн архивын цогцолбор барилгатай танилцаж, туршлага судалж, Геологийн баримтын төв архивын цогцолбор барилгын угсралтын ажлын төсөв боловсруулан мэргэшсэн төсөвчинд хянуулж байна.<br>Геологийн баримтын төв архивын цогцолбор барилгын угсралтын ажлын төсөв боловсруулан, мэргэшсэн төсөвчнөөр хянуулсан.<br>*Хүрсэн түвшин: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Сангийн яаманд хүргүүлсэн бөгөөд санхүүжилтийг хүлээж байна.* | 100 | 100 |
| 41 | 4.1.4 | Архивын зориулалттай нягтруулсан тавиур шүүгээг засварлах, сайжруулах | | Архивын 6 хадгаламжийн 368 нягтруулсан шүүгээнд баримт хадгалдаг. | 0 | 1 | *Хүрсэн түвшин: Геологийн баримтын төв архивын хадгаламжийн сангийн 254 нягтруулсан шүүгээнд засвар үйлчилгээ хийлгэсэн.* | 100 | 100 |
| Зорилт 4.2. Архивын үйлчилгээг боловсронгуй болгох, зохион байгуулах /ҮГА-ны Стратеги төлөвлөгөө 4.2/ | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 42 | 4.2.1 | Үйлчилгээний дугаарлалтын автомат систем нэвтрүүлэх асуудлыг судална. | - | Ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагын систем судалсан эсэх<br>0 – Үгүй<br>1–Тийм | 0 | 1 | Үйлчилгээний автомат дугаарлалтын систем ашиглан үйл ажиллагаа явуулдаг Архивын ерөнхий газар, Нийслэлийн архивын газар, Тагнуулын ерөнхий газрын архив, Хил хамгаалах ерөнхий газрын архив, Төв аймгийн архив, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн архивын нэг цэгийн үйлчилгээ, уншлагын танхимтай танилцаж, тэдгээрт хэрэглэгддэг үйлчилгээний дугаарлалтын автомат системийн үнийн судалгаа авсан.<br>*Хүрсэн түвшин: ҮГА-ны 2024 оны тоног төхөөрөмжийн худалдан авалтын төлөвлөгөөнд үйлчилгээний дугаарлалтын автомат машин худалдан авах санал боловсруулж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Сангийн яаманд хүргүүлсэн. Санхүүжилт хүлээгдэж байна.* | 100 | 100 |
| 43 | 4.2.2 | Уншлагын танхим дахь эрэл-хайлтын программ хангамжийг сайжруулж, үйлчилгээг түргэн шуурхай болгоно. | - | Түргэн шуурхай болгосон эсэх:<br>0 – Үгүй<br>1–Тийм | 0 | 1 | Геологийн баримтын төв архивын уншлагын танхимд эрэл-хайлтын мэдрэгчтэй дэлгэцийн систем ашигладаг ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг Архивын ерөнхий газар, Нийслэлийн архивын газар, Тагнуулын ерөнхий газрын архив, Хил хамгаалах ерөнхий газрын архив, Төв аймгийн архив, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн архивын нэг цэгийн үйлчилгээ, уншлагын танхимтай танилцаж, үйлчилгээнд хэрэглэгддэг эрэл-хайлтын программ хангамж түүнийг суурилуулсан мэдрэгчтэй дэлгэц бүхий тоног төхөөрөмжийн үнийн судалгааг авсан.<br>Судалгааг үндэслэж, ҮГА-ны 2024 оны тоног төхөөрөмжийн худалдан авалтад уншлагын танхимд ашиглах мэдрэгчтэй дэлгэц нэгийг худалдан авах санал боловсруулсан.<br>Эрэл-хайлтын үйл ажиллагаанд ашиглах программ хангамжийн сонголтыг эцэслэн өмнөх жилүүдэд хэрэглэж байсан Arc4u программын өгөгдлийн санг баяжуулах ажлын зэрэгцээ түүнийг шинээр зохиогдсон Edoc архивын данс бүртгэлийн программ руу | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шилжүүлэн хөрвүүлэх ажлыг Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Цахим архив-1-2022" төслийн хүрээнд гүйцэтгэж байна.<br>*Хүрсэн түвшин: Эрэл-хайлтын үйл ажиллагаанд ашиглах програм хангамжийн сонголтыг эцэслэн өмнөх жилүүдэд хэрэглэж байсан Arc4u программын өгөгдлийн санг баяжуулах ажлын зэрэгцээ түүнийг шинээр зохиогдсон Edoc архивын данс бүртгэлийн програм руу шилжүүлэн хөрвүүлэх ажлыг УТХ-өөр хэрэгжиж буй "Цахим архив-1-2022" төслийн хүрээнд гүйцэтгэсэн.* | | |
| 44 | 4.2.3 | Онлайн лавлагаа гаргадаг болгох, программ хангамж сайжруулна. | - | Онлайн лавлагааны систем нэвтрүүлсэн эсэх:<br>0 – Үгүй<br>1–Тийм | 0 | 1 | Онлайн лавлагаа гаргах, цахим үйлчилгээ үзүүлэх архивын үйлчилгээний ОЛС системээс үйлчилгээ авах иргэдэд зориулсан "Цахимаар тайлан захиалах заавар" нэртэй гарын авлагыг Цахим архив-1-2022 төсөлтэй хамтран боловсруулсан. Онлайн лавлагааны системээр нийт 15 үйлчлүүлэгчийн 45 тайлангаас хуулбар авах захиалгыг хүлээн авч А4 форматаар 142 хуудас, А3 форматаар 28 хуудас баримтыг хуулбарлаж өгсөн.<br>*Хүрсэн түвшин: УТХ-өөр хэрэгжиж буй "Цахим архив-1-2022" төслийн хүрээнд "ОЛС" онлайн лавлагааны системийг нэвтрүүлэх ажлын гүйцэтгэлийн тайлан дуусаж, шинжээчээр хянагдсан.* | 100 | 70 |
| Зорилт 4.3. Газрын хэвлийн тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомжуудын хүрээнд газрын хэвлийд хийгдсэн бүх төрлийн судалгааны ажлын тайлан мэдээг нэгтгэн хүлээн авах, тайлан мэдээг тогтмол гаргах | | | | | | | | | |
| 45 | 4.3.1 | Геологи, уул уурхайн судалгааны бүх үе шатны баримтыг хүлээн авах, сан хөмрөгөө баяжуулах, төвлөрүүлэн хадгална. | - | Хүлээн авсан тайлан | 0 | 110 | Архивын сан хөмрөгийг геологи, уул уурхайн судалгааны бүх төрлийн баримтаар баяжуулах /нөхөн бүрдүүлэх-Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль/ зорилгоор хадгаламжийн нэгжийг хүлээн авсан. Үүнд:<br>- Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан – 76<br>- 1:50000 масштабтай зураглалын ажлын үр дүнгийн тайлан – 10<br>- Шинжлэх ухаан технологийн сан- 244<br>-Орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэл – 134 | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Цахим баримт- 647 /CD, DVD/.<br>*Хүрсэн түвшин: **464** тайлангийн **3660** хадгаламжийн нэгж болон цахим баримт 647-г хүлээн авсан.* | | |
| 46 | 4.3.2 | Монгол Улсын чулуун дээжийг хүлээн авч, цахим санг бүрдүүлэх, тулгуур зүсэлт гаргах боломжийг бүрдүүлнэ. | - | Тулгуур зүсэлт гаргах боломж бүрдүүлсэн эсэх:<br>0 – Үгүй<br>1–Тийм | 0 | 1 | Улсын болон хувийн хөрөнгөөр хийгдсэн бүх төрөл, шатны геологийн судалгааны ажлын үр дүнгийн тайланг дагалдаж тушаасан чулуун дээжийг хүлээн авч цахим сан бүрдүүлэх ажлын хүрээнд<br>- Чөмгөн дээж 56ш<br>- Чулуун дээж 356ш<br>- Аншлиф 257ш<br>- Тунгалаг шлиф-1081ш<br>- Шлих- 212ш тус тус хүлээн авч, хадгаламжийн нэгжийн нэг бүрчилсэн бүртгэлийг архивын данс бүртгэл, эрэлт хайлтын Arc4U программд оруулсан.<br>*Хүрсэн түвшин: Чулуун дээжийн цахим санд нийт 5 төрлийн 1962 дээжийн мэдээллийг бүртгэн оруулсан.* | 100 | 100 |
| 47 | 4.3.3 | Газрын хэвлийд хийгдсэн бүх төрлийн судалгааны ажлын тайлан мэдээ, мэргэжлийн ном сэтгүүл, эрдэм шинжилгээний бүтээл, гарын авлага хүлээн авах | - | Архивын сан хөмрөгийг баяжуулсан тоо | 0 | 1500 | Шинжлэх ухаан технологийн санд бүртгэлтэй байгалийн шинжлэх ухаан, уул уурхай, геологийн судалгааны ажлын баримтыг татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, 244 тайлангийн 2459 хадгаламжийн нэгжээр архивын сан хөмрөгийг баяжуулсан<br>-Зохиогч Г.Жамсрандорж, Ю.Б. Миронов нарын "Минерально-Сырьевая База Урана Монголии", П.Шаандар Ш.Өлзий-Орших нарын "Металл бус ашигт малтмалын ордын эрлийн цогцолбор арга" нэртэй 2 бүтээлээр архивын номын санг баяжуулсан.<br>*Хүрсэн түвшин: Архивын сан хөмрөг 1500 нэгжээр баяжигдсан.* | 100 | 100 |
| Зорилт 4.4. Архивын үйл ажиллагааг олон улсын, ижил төстэй архивын сан хөмрөгтэй харьцуулан судалж, нэгдсэн бүртгэлд гишүүнчлэлээр элсэж, үйл ажиллагааг тогтмол сайжруулах | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 48 | 4.4.1 | Ижил төстэй архивын асуудлаар Солонгос, Польш болон бусад гадаад орнуудын архивын байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх, Монгол улсын геологийн салбарт холбогдох баримтыг илрүүлэх, хуулбарлан авах | - | Туршлага судалсан эсэх:<br>0 – Үгүй<br>1–Тийм | 0 | 1 | Ижил төстэй архивын асуудлаар туршлага судлах хамтын ажиллагааг хөгжүүлэх ажлын хүрээнд ОХУ-ын геологич Антонов Павел Владимировичид Геологийн баримтын төв архивын өдөр тутмын үйл ажиллагааг танилцуулж, архивын баримтыг нээн илрүүлэх тухай санал солилцсон.<br>*Хүрсэн түвшин: ШУТСангаас нийт 244 тайлангийн 21578 хуудас цаасан баримт, цахим хувийг хуулбарлан авч үйлчилгээнд гаргахад бэлэн болсон.* | 100 | 100 |
| 49 | 4.4.2 | Геологийн баримтын төв архивд геологийн судалгааны тайлан хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, үйл ажиллагааг зохицуулах "Дотоод журам" боловсруулж, батлуулна. | - | Батлуулсан эсэх:<br>0 – Үгүй<br>1–Тийм | 0 | 1 | "Геологийн баримтын төв архивын үйл ажиллагаанд ашиглах журам"-ын төсөл, журмыг албажуулах тушаалын төсөл, журмын төсөл боловсруулах шалтгаан, тайлбарын танилцуулгын төсөл, Геологийн баримтын төв архивын үйл ажиллагаанд ашиглаж байсан Ашигт малтмал газрын даргын 2016 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/30 дугаар тушаалаар баталсан "Геологийн тайлан хүлээн авах, бүртгэх, хадгалах, ашиглах журам"-ыг хүчингүй болгох тухай албан бичгийг боловсруулж, АМГТГ-т хүргүүлсэн.<br>*Хүрсэн түвшин: Архивын үйл ажиллагааг зохицуулах Дотоод журмын төсөлд санал авахаар дотоод сүлжээгээр дамжуулан иргэд, олон нийтээс болон албан хаагчдаас нээлттэй санал авч, боловсруулсан.* | 90 | 70 |
| 50 | 4.4.3 | Техник, эдийн засгийн үндэслэл, Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, Зураглалын тайлан архивд хүлээн авах "Заавар" боловсруулж, батлуулна. | - | Батлуулсан эсэх:<br>0 – Үгүй<br>1–Тийм | 0 | 1 | Зааврын төслийг Үндэсний геологийн албаны цахим хуудсанд байршуулж, хөмрөг үүсгэгч аж ахуйн нэгжүүдээс санал авч, шинэчлэн боловсруулсан.<br>*Хүрсэн түвшин: Боловсруулсан заавын төслүүд:*<br>*- Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн судалгааны ажлын тайлан хүлээн авах заавар*<br>*- Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан хүлээн авах заавар*<br>*- Техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах заавар* | 90 | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 4.5. Иргэд, хуулийн этгээдэд Төрийн архивын баримтаар түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх, Улсын төсөвт орлого төвлөрүүлэх | | | | | | | | | |
| 51 | 4.5.1 | Төрийн архивын үйлчилгээ үзүүлэх, Улсын төсөвт орлого төвлөрүүлнэ. | - | Улсын төсөвт төвлөрүүлэх орлого | 0 | 140 | Улсын төсөвт 2024 оны хагас жилийн байдлаар нийт 203'128'500 төгрөгийн орлого төвлөрүүлэн ажилласан. Үүнд:<br>• тайлан уншлага-27'070'500 төгрөг,<br>• канон-77'126'500 төгрөг,<br>• сканер-92'059'500төгрөг<br>• Аж ахуйн нэгжүүд төрийн сангийн дансанд урьдчилан байршуулсан мөнгөн дүн-6'872'000төгрөг.<br>• Мэдээлэл боловсруулж ийн үйлчилгээнээс 19,608,000 төгрөг.<br>*Хүрсэн түвшин: Улсын төсөвт оруулсан нийт орлого 279 сая төгрөг ба орлого 153 хувиар давуулан биелүүлсэн.* | 100 | 100 |
| **ЗОРИЛГО 5. [illegible] хөрөнгө санхүүгийн [illegible] оновчтой [illegible] батлуулах, мөрдүүлэх [illegible] сурталчлах, [illegible] үнэлгээний асуудал [illegible] хэрэгжүүлэх** | | | | | | | | | |
| Зорилт 5.1. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах /ҮГА-ны Стратеги төлөвлөгөө 5.1/ | | | | | | | | | |
| 52 | 5.1.1 | Засгийн газрын 2005 оны Иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай 67 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах, удирдах дээд байгууллагад хүргүүлнэ. | - | Шийдвэрлэлтийн хувь | 0 | 99% | 2024 онд Үндэсний геологийн албанд өргөдөл, гомдол 23 ирсэн байна. Үүнд:<br>-Хүний нөөцийн чиглэлээр албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл 21,<br>-Гео-мэдээллийн төвөөс мэдээлэл хүссэн 1 өргөдөл,<br>-Геологийн баримтын төв архиваас мэдээлэл хүссэн 1 өргөдөл тус тус байна.<br>Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 100%-ийн хэрэгжилттэй байна.<br>-2024 онд Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн өргөдөл гомдлын цахим сайтад ҮГА-нд холбогдох гомдол ирээгүй.<br>-"Төв эрдэнэ сант" ХХК-ийн нэхэмжлэлтэй Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэст холбогдох захиргааны хэрэгт гуравдагч этгээдээр шүүх хуралдаанд оролцож, шийдвэр гарах шатанд явж байна. | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 53 | 5.1.2 | Төрийн албан хаагчийн мэдээ мэдээлэл, шилжилт хөдөлгөөнийг зохион байгуулж, Төрийн албаны зөвлөлд тайлагнана. | - | Мэдээ тайлангийн тоо | 0 | .1 | Төрийн албаны зөвлөлд ҮГА-ны шилжилт хөдөлгөөний мэдээлэл болон бусад холбогдох 2023 оны тайлан мэдээг дараа жилийн 1 дүгээр сард буюу 2024 оны 01 дүгээр сарын 03-нд цахим хэлбэрээр хүргүүлсэн.<br>-Тайлант хугацаанд Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн программд албан хаагчдын мэдээлэлд шаардлагатай өөрчлөлт хөдөлгөөнийг бүртгэсэн. Үүнд: Ажлаас чөлөөлөгдсөн 9, ажилд томилогдсон 7, жирэмсний болон амаржсаны амралт олгосон 1, хавсран гүйцэтгүүлсэн 3 нийт давхардсан тоогоор 31 албан хаагчийн хөдөлгөөнийг бүртгэсэн.<br>-ЗГ-ын Төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2024 оны 128 дугаар тогтоолын дагуу Төрийн албаны хүний нөөцийн системийн код шинэчлэгдэн, дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>1.Нийт албан хаагчдын хувийн мэдээллийг шинэчилж, цалин хөлсний мэдээллийг хүний нөөцийн системд оруулснаар, ЗГ-ын тогтоолд нийцүүлэн цалинжуулах боломжтой болсон.<br>2.Бүх ажилчдын ажилласан хугацааг Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн бүртгэлтэй нэг бүрчлэн тулгаж, үнэн зөв бүртгэсэн.<br>ТАЗ-ын хүний нөөцийн системд шивэгдэж орсон албан хаагчийн цалин хөлсний талаар:<br>*Хүрсэн түвшин: ЗГ-ын 128 дугаар тогтоолоор батлагдсан цалингийн нэмэгдэлтэй уялдуулан Албаны даргын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн -А/22 дугаар тушаалаар Төрийн үйлчилгээний /ТҮ болон ТҮМ/ нийт 19 албан хаагчийн,*<br>*-А/23 дугаар тушаалаар нийт 10 төрийн жинхэнэ албан хаагчийн цалингийн нэмэгдлийг тус тус баталгаажуулсан.*<br>*-ЗГ-ын 128 дугаар тогтоолын хэрэгжилт хангагдсан.* | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 54 | 5.1.3 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Үндэсний геологийн албаны нийтийн албан тушаал тны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогыг мэдүүлгийг https://meduuleg.iaac.mn цахим хуудсаар шинэчлэн бүртгүүлж баталгаажуулах ажлыг зохион байгуулах, холбогдох тайланг боловсруулж, Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ. | - | Мэдүүлэг гаргасан албан тушаалтан /тоогоор/ | 0 | 10 | Үндэсний геологийн албаны албан хаагчдын 2023 оны ХАСХОМ-ийг хуульд заасан хугацаанд шинэчлэн гаргуулж холбогдох тайлан мэдээг цахим системд нэгтгэх чиглэлээр дараах ажлуудыг гүйцэтгэлээ. Үүнд:<br>1. Байгууллагын тайлан мэдээг үнэн зөв бодитой гаргах үүднээс http://meduuleg.iaac.mn системд хандаж 2023 оны ХАСХОМ-ийг шинэчлэн гаргасан мэдүүлэг бүрийг хянаж баталгаажуулсан.<br>2. Цахим системд “ХАСХОМ хүлээн авсан тухай бүртгэл”, “Мэдэгдэл тайлбар тэдгээрийн шийдвэрлэлтийн бүртгэл”, “ХАС-ын урьдчилсан мэдүүлгийн бүртгэл” зэрэг бүртгэлийг мэдүүлэгч гаргагч тус бүрээр бүртгэсэн.<br>3. Цахим системд ХАС-ын хураангуй, ХОМ-ын хураангуй тайланг уншуулж, PDF файлаар enkhjin@iaac.mn и-мэйл хаягаар хүргүүлсэн.<br>4. Тус албаны албан хаагчдын хувийн ашиг сонирхолын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн 2023 оны тайлан буюу ХАСХОМ-1 тайланг гаргаж 2024-02-28-ны өдрийн 1/146 тоотоор АТГ-т хүргүүлсэн.<br>• 2024 оны хагас жилийн байдлаар ХАСХОМ гаргавал зохих 19 төрийн захиргааны албан хаагч байхаас 4 сул ажлын байр нөхөгдөөгүй тул 15 албан хаагчийн ХАСХОМ-ыг шаардлагатай засвар, өөрчлөлтийг хийлгүүлэн, хуулийн хугацаанд баталгаажуулах ажлыг гүйцэтгэсэн.<br>• Тайлант хугацаанд хөрөнгө, орлогод орсон их хэмжээний өөрчлөлт 1-ийг бүртгэсэн. Шинээр томилогдох болон ажил хавсран гүйцэтгэхтэй холбоотой 3 албан хаагчийн ХАСУМ эрх нээх хүсэлтийг хүргүүлж шийдвэрлүүлсэн.<br>• ҮГА-ны Авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан. | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | • Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу хөрөнгө оруулгын мэдүүлгийг гаргах, бүртгэх, хадгалах зарим эрх зүйн зохицуулалтууд шинэчлэгдсэнтэй холбогдуулан АТГ-аас зохион байгуулсан сургалтуудад хамрагдсан. | | |
| 55 | 5.1.4 | Гадаадын ижил төстэй байгууллагуудтай байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хэрэгжилтийг хангаж, хамтын ажиллагааг идэвхжүүлнэ. | - | БНПУ, БНСУ, БНФУ-ын үндэсний геологийн албадтай хэрэгжүүлсэн ажлын тоо | 0 | 3 | 1. 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр байгуулсан "Хамтран ажиллах тухай Үндэсний геологийн алба болон Польшийн геологийн хүрээлэн хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг"-ийн хүрээнд "Бэлийн булаг, Задгай булаг дахь молибден, гянтболд судлах төсөл хэрэгжүүлэх тухай гүйцэтгэлийн гэрээ"-г 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр байгуулсан. Төслийг 2024-2026 онуудад хэрэгжүүлэх бөгөөд 2024 онд гүйцэтгэх хээрийн судалгааны бэлтгэл ажлыг хангасан.<br>2. 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан "Дэлхий судлалын чиглэлээр хамтран ажиллах тухай Монгол Улсын Үндэсний геологийн алба, БНСУ-ын Гео шинжлэх ухаан, эрдэс баялгийн хүрээлэн хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг"-ийн хүрээнд талууд Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутагт байрлах Хаг талбайд ховор металлын эрэл судалгааны ажил гүйцэтгэх зорилгоор "Хамтран ажиллах гэрээ"-г 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс 10 дугаар сарын 03-ны өдрийг хүртэл хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэсэн.<br>3. 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдөр байгуулсан "Геологийн шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны чиглэлээр хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газрын Хэрэгжүүлэгч агентлаг Үндэсний геологийн алба, БНФУ-ын Геологи, уул уурхайн судалгааны товчоо хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг"-ийн | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүрээнд "Литий Монгол" судалгааны хамтарсан төслийг эхлүүлж эхний хээрийн судалгааны ажлыг зохион байгуулсан. Төсөлд ҮГА-аас гадна ШУА-ийн Геологийн хүрээлэн, ШУТИС, МУИС-ийн төлөөллүүд хамтран оролцсон. | | |
| 56 | 5.1.5 | Дотоод, гадаадын ижил төстэй байгууллага, эрдэм шинжилгээний хүрээлэн, байгууллагуудтай хамтын ажиллагааг эхлүүлэх ажлыг зохион байгуулах, хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлнэ. | - | Шинээр байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичиг, хамтын ажиллагааны гэрээ /тоогоор/ | 0 | 2 | 1. "Геологийн шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны чиглэлээр хамтран ажиллах тухай Монгол Улсын Үндэсний геологийн алба, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Судалгаа Инновацийн газрыг төлөөлж Британийн геологийн алба хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг"-ийг тус улсын Гадаад хэргийг сайд Д.Камерун 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр Монгол Улсад хийсэн албан айлчлалын үеэр байгуулсан бөгөөд хамтарсан судалгааны ажлыг 2025 оны I дүгээр улиралд гүйцэтгэхээр айлын талтай эцэслэн тохирсон.<br>2. Канад Улсын Геологийн албаны удирдлагуудтай уулзаж байгууллага хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг байгуулахаар тохирсон бөгөөд санамж бичгийн төслийг Канадын талд хүргүүлсэн. Мөн Канад Улсын Байгалийн яамны техникийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 2024-2025 онд агаарын геофизикийн чиглэлээр хамтарсан төсөл хэрэгжүүлэх шийдвэр албажсан болно. Уг төслийн хүрээнд Канадын геологийн албаны 2 мэргэжилтэн Улаанбаатар хотноо хүрэлцэн ирж хамтарсан хээрийн судалгааны ажил гүйцэтгэхээр төлөвлөж байна.<br>3. "Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Үндэсний геологийн алба болон Монгол Улсын Шинжлэх ухааны академи хоорондын хамтын ажиллагааны санамж бичиг"-ийг 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр байгуулсан. Уг санамж бичгийн хүрээнд Одон орон геофизикийн хүрээлэнтэй хамтран "Хүрээлэн орчны гамшгийн эрдэс" сэдэвт олон улсын | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эрдэм шинжилгээний анхдугаар бага хурлыг Булган Архангай аймгуудын нутаг 2024 оны 8 дугаар сарын 16-20-ны өдрүүдэд зохион байгуулсан.<br>4. "Геологи, уул уурхайн салбарын мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, чадавхжуулах болон хамтарсан сургалт, судалгааг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах тухай Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Үндэсний геологийн алба болон МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг"-ийг 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр байгуулсан. Уг санамж бичгийн хүрээнд тус сургуулийн 2 багш ҮГА, ГСШТ ажилтан албан хаагчдад Петрографи, минераграфикийн сургалтыг 2024 оны 06 дугаар сарын 8-ны өдрөөс 07 дугаар сарын 5-ны өдрүүдэд зохион байгуулсан.<br>5. "Геологи, уул уурхайн салбарын мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, чадавхжуулах болон хамтарсан сургалт, судалгааг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах тухай Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Үндэсний геологийн алба болон ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургууль хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг"-ийг 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдөр байгуулсан. Уг санамж бичгийн хүрээнд геологийн салбарын хүний нөөцийн бодлогыг дэмжих зорилгоор уг чиглэлээр амжилттай суралцаж буй 5 оюутны 1 жилийн сургалтын төлбөрийг шийдвэрлэсэн. | | |
| 57 | 5.1.6 | Монгол Улсад Геологийн салбар үүсэж хөгжсөний 85 жилийн арга хэмжээ зохион байгуулна. | - | Хэрэгжүүлсэн ажлын тоо | 0 | 1 | Монгол Улсад Геологийн салбар үүсэж хөгжсөний 85 жилийн арга хэмжээ зохион байгуулсан.<br>Ойн арга хэмжээний хүрээнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Үндэсний геологийн алба, Монголын Геологийн холбоодын нэгдсэн зөвлөл хамтран "Геологичдын ажил мэргэжлийн уралдаан"-ыг 09 дүгээр сарын 27-ноос 09 дүгээр сарын 30-ны өдрүүдэд Орхон | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | аймгийн Баян-Өндөр сумын нутаг Оросын булаг хэмээх газар амжилттай зохион байгуулж, уралдаанд нийт 21 байгууллагын 150 орчим албан хаагчид оролцож мэргэжлийн ур чадвараа сорьж, туршлага мэдээлэл солилцов.<br>ҮГА-аас ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурал, баярын хурал, спортын өдөрлөг зэрэг арга хэмжээг 2024 оны 10 дугаар сарын 17-18-ын өдрүүдэд амжилттай зохион байгуулав. Хурлын арга хэмжээний хөтөлбөрийн дагуу бүх үйл ажиллагааны зохион байгуулалт, холбогдох санхүүжилтийг хариуцсан ажилласан. | | |
| 58 | 5.1.7 | Дэлхийн геологийн конгресс-2024-тэй уялдуулан хээрийн ажил зохион байгуулна. | - | Зохион байгуулсан эсэх:<br>0-Үгүй<br>1-Тийм | 0 | 1 | Дэлхийн геологийн конгресс-2024 /IGC2024/ ийн хүрээнд Монгол Улсад явагдах хээрийн судалгааны ажилд оролцох хүсэлтээ Post-Congress Field Trip - IGC 2024 (micehub.com) вэб хаягаар илгээж баталгаажуулах ажлыг зохион байгууллаа.<br>ҮГА Олон улсын геологийн 37 дугаар конгрессын зохион байгуулах хороотой байгуулсан санамж бичгийн хүрээнд геологийн хувьд сонирхолтой өвөрмөц тогтоц бүхий Адаацагийн офиолит-Дэмчогийн хийд-Ханбогдын шүлтлэг боржингийн массив-Шар цав-Байшин цав-Дэл уул-Цагаан суварга гэсэн маршрутын дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд, Манлай сумд болон Дундговь аймгийн Өлзийт сумдын нутаг дэвсгэрт хээрийн аяллыг 08-р сарын 31-ээс 09-р сарын 04-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулж олон улсын геологичдод МУ-ын геологи судалгааны өнөөгийн байдал, хэтийн төлөвийг сурталчлан ажиллав.<br>Уг арга хэмжээнд гадны 5 судлаач эрдэмтэд оролцсон. | 100 | 100 |
| 59 | 5.1.8 | Жендэрийн мэдрэмжтэй удирдлагаар хангах, сургалт зохион байгуулна. | - | Сургалт зохион байгуулсан эсэх<br>0-Үгүй;<br>1-Тийм | 0 | 1 | Жендерийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүнгийн 2023 оны мэдээг ЖҮХ-ны мэргэжилтэнд 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр мэйлээр хүргүүлсэн. Албаны албан хаагчдын хүйсийн тэнцвэрт | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байдлын жилийн мэдээг гаргаж, УУХҮЯ-д хүргүүлсэн.<br>Жендерийн үндэсний хорооноос 2024 оны 03 дугаар сарын 02-нд зохион байгуулсан "Жендерийн үндэсний сургагч багш бэлтгэх" сургалтад хамрагдсанаар албан хаагчдын хүйсийн тэнцвэрт байдалтай холбоотой ёс зүйн харилцаа, багаар ажиллах талаарх сургалтад хамрагдав.<br>Жендерийн эрх тэгш байдлын тухай хуульд заасан төрийн байгууллагын хүлээх эрэгтэй, эмэгтэй хүний эрх тэгш байдлыг хангах хариуцлагын зарчим болон "Хүйсийн 60:40 гэсэн харьцаа бүхий тэнцвэрт байдлыг хангах" заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. ҮГА-нд эрэгтэй албан хаагч 10, эмэгтэй албан хаагч 20 буюу 63:37 хүйсийн харьцаатай ажиллаж байна.<br>2024 оны 05 дугаар сарын 15-18-нд Өмнөговь аймгийн Даланзадгад, Ханбогд суманд зохион байгуулагдсан "Хүний нөөц, жендерийн манлайлагч, эмэгтэйчүүдийн нэгдсэн чуулга уулзалт"-д 7 албан хаагч хамрагдсан. | | |
| 60 | 5.1.9 | Албан хэрэг хөтлөлтийн стандарт, зааврын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллана. | - | Албан хэрэг хөтлөлтийн хувь | 0 | 92% | Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмыг ажилдаа нэвтрүүлэн, албан хаагчдын өдөр тутмын ажилд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.<br>2024 онд ҮГА-нд нийт ирсэн бичиг 1142, явсан бичиг 699, өргөдөл гомдол 23, албан бичгийн шийдвэрлэлт 97.6 хувьтай ажиллав.<br>АЕГ-ын сургалтын төлөвлөгөөнд оруулсан "Баримт бичгийн арга зүй" сэдэвт мэргэшүүлэх цахим сургалтад 2024 оны 03 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд хамрагдсан. 2024 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад нэгжүүдээс санал авч байна.<br>Хүрсэн түвшин: 2023 онд хөтлөгдөж дууссан баримт бичгийг стандартын дагуу хэрэг бүрдүүлж, архивд хүлээн авч, бүртгэсэн. | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 61 | 5.1.10 | Mining week-2024 арга хэмжээг зохион байгуулж оролцоно. | | Зохион байгуулсан эсэх: 0-үгүй 1-тийм | 0 | 1 | Mining week-2024 арга хэмжээ 2024 оны 10 дугаар сарын 02-05-ны өдрүүдэд зохион байгуулагдав. Эрдэс баялгийн салбарын ил тод, нээлттэй байдлыг хангах, олон талт оролцоог дэмжих зорилготой "Уул уурхайн 7 хоног-2024" чуулга уулзалт зохион байгуулах ажилд албаны бүрэлдэхүүн оролцож ажиллав. ЭБСТЭЗХ-ийн дарга Н.Мөнхбилэг Чухал ашигт малтмалын талаарх геологи судалгаа сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн бөгөөд Чухал ашигт малтмалын тогтвортой хөгжил ба дэлхийн ханган нийлүүлэлт дэх боломжууд сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулав. | 100 | 100 |
| 62 | 5.1.11 | Гамшгаас хамгаалах бэлэн байдлын улсын үзлэгийн бэлтгэл ажлыг зохион байгуулна. | | Зохион байгуулсан эсэх: 0-үгүй 1-тийм | 0 | 1 | Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5 дахь хэсэг, 8.4 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.6 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэг, Хөдөлмөрийн дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Геологийн судалгааны хэлтсийн гидрогеологи, геоэкологи, хөрс, геотехникийн судалгаа хариуцсан мэргэжилтэн Д.Одонтуяад Үндэсний геологийн албаны Гамшгаас хамгаалах асуудлыг хавсран гүйцэтгүүлж байна. Гамшгаас хамгаалах орон тооны бус мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн болон ажилтныг томилуулах тушаалын төслийг батлуулсан. ОБЕГ-ын байранд 2024 оны 04 дүгээр сарын 27-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрүүдэд Зудын нөхцөл байдалтай холбогдуулан зарласан өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд ҮГА-наас улсын онцгой комиссын шуурхай штабт төлөөлөл оролцож ажилласан. | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газраас салбарын мэргэжлийн байгууллага, холбоодтой хамтран "БАЙГАЛИЙН ГАМШГИЙН ЭСРЭГ БАЯЛАГ БҮТЭЭГЧИД ХАМТДАА" аяныг салбарын хэмжээнд өрнүүлсэн.<br>Аянд Үндэсний геологийн алба, Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ,Монгол геологийн холбоодын нэгдсэн зөвлөл, Монголын уул уурхайн мэргэжлийн холбоодын зөвлөл, Монголын газрын тосны бүтээгдэхүүн импортлогчдын мэргэжлийн холбоо, Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци, Монголын Үйлдвэрлэлийн Геологичдын Холбоо хамтран " оролцож, ҮГА-ны ажилтнууд нэг өдрийн цалингаа хандивласан. | | |
| Зорилт 5.2. Салбарын мэргэжилтэй боловсон хүчний чадавхыг дээшлүүлэх, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах | | | | | | | | | |
| 63 | 5.2.1 | Хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг холбогдох яам, байгууллагатай зохион байгуулах, ажилтан, албан хаагчдыг богино, дунд хугацаат сургалтад жигд хамруулах ажлыг зохион байгуулна. | - | Хамрагдсан албан хаагчдын тоо | 0 | | 2024 онд ҮГА-наас албан хаагчид дараах сургалтад хамрагдсан. Үүнд:<br>*Танхимаар:*<br>-АТГ-ын ХАСХОМ-ын сургалт 2024 оны 01 дүгээр сарын 31-нд нийт 10 төрийн албан хаагч,<br>-Удирдлагын академид Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах тухай сургалт 2024 оны 03 дугаар сарын 18-19, 1 албан хаагч,<br>Төрийн албан хаагчийн гүйцэтгэл, үр дүн, төрийн байгууллагын бүтээмжийг дэмжих 2024 оны 02 дугаар сарын 26-нд 2 албан хаагч,<br>-Монгол бичгийн сургалт 2024 оны 04 дүгээр сарын 01-05.01, 29 албан хаагч,<br>-Төрийн албан хаагчийн хөгжил хамгаалал "Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай" 2024 оны 03 дугаар сарын 25, 2 албан хаагч,<br>-ЗГХЭГ-ын Засгийн газрын хүний нөөцийн газар "Засгийн газрын хүний нөөцийн | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бодлогыг дэмжих цахим систем" 2024 оны 05 дугаар сарын 27, 5 албан хаагч,<br>-А3 сертификаттай сургалтад 6 албан хаагч.<br><br>*ТАЗ-ийн цахим сургалтад:*<br>-2024 оны 01 дүгээр сарын 28-нд зохион байгуулагдсан сургалтад 17 албан хаагч,<br>-2024 оны 04 дүгээр 18-нд зохион байгуулагдсан сургалтад 15 албан хаагч,<br>-2024 оны 05 дугаар сарын 09-нд зохион байгуулагдсан сургалтад 21 албан хаагч.<br>*Бусад цахимаар:*<br>-2024 оны 01 дүгээр сарын 10-аас нийт албан хаагчид Эйбл программын сургалтад 30 албан хаагч.<br>Төрийн албаны мэргэжил дээшлүүлэх сургуулийн дунд хугацааны:<br>-Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 2 албан хаагч /ЭБСТЭЗХ/,<br>-Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх сургалтад 2 албан хаагч /ТЗУХ/,<br>-Ахлах түшмэлийн сургалтад 1 албан хаагч /ТЗУХ/<br>-Эрхэлсэн түшмэлийн сургалтад 2 албан хаагч/<br>Тэргүүн түшмэлийн сургалтад 2, /нийт давхардсан тоогоор 82 албан хаагч хамрагдсан.<br>*Хэлний мэдлэгээ дээшлүүлэх сургалт:*<br>Talk talk English сургалтын байгууллагад нийт 5 албан хаагч хамрагдаж, шалгалтаа амжилттай өгсөн албан хаагчид дээд түвшинд шилжин суралцаж байна.<br>*Хүрсэн түвшин: Албан хаагчид сурсан мэдсэнээ ажилдаа хэрэгжүүлсэн.* | | |
| 64 | 5.2.2 | Төрийн албан хаагчдыг ажиллах нөхцөлөөр хангах, эрүүл мэндийн үзлэгт хамруулна. | - | Хамруулсан эсэх:<br>0-Үгүй<br>1-Тийм | 0 | 1 | Нийт 32 албан хаагчийг Монгол Японы эмнэлэгт эмнэлгийн үзлэгт хамруулсан. Тус эмнэлэгтэй тооцоо хийж, гэрээний үүргийг биелүүлсэн тухай акт үйлдсэн. | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Албан хаагчдыг дотоод шүүрлийн, хоол боловсруулах, зүрх судас зэрэг эрүүл мэндийн нарийвчилсан үзлэг шинжилгээнд хамруулан ажиллав. Байгууллагын албан хаагчдыг ажиллах нөхцөлөөр хангах чиглэлээр бүх албан хаагчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр хангах, ГБТАрхивын зарим тоног төхөөрөмжийг нүүлгэн шилжүүлж ажлын байрны зохион байгуулалтыг сайжруулах, байгууллагын архивын тоног төхөөрөмжийг худалдан авах зэрэг ажлыг гүйцэтгэсэн. | | |
| Зорилт 5.3. Үндэсний геологийн албаны Стратеги төлөвлөгөөний 5 дугаар зорилго, Зорилт 2. Салбарын хууль, эрх зүйн орчны харилцааг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх | | | | | | | | | |
| 65 | 5.3.1 | Газрын хэвлийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулах ажлын хэсэгт санал хүргүүлнэ. | | Хүргүүлсэн эсэх:<br>0-Үгүй<br>1-Тийм | 0 | 1 | УУХҮ-ийн сайдын 2023 оны 11-р сарын 08-ны өдрийн А/325 тоот тушаалаар батлагдсан Газрын хэвлийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулах ажлын хэсэгт хамрагдаж, уг хуульд ҮГА-аас өгөх саналыг ажлын шугамаар хүргүүлсэн.<br>Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны комиссын Газрын хэвлийн ашиглалтын хамтарсан дэд комиссын 2024 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн ээлжит хуралд оролцож хоёр орны геологи, эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр харилцан санал солилцсон. | 70 | 70 |
| 66 | 5.3.2 | Геологи судалгааны чиглэлээрх холбогдох дүрэм журмыг боловсронгуй болгох, хэрэгжилтэд хяналт тавина. | - | Холбогдох бичиг баримт боловсронгуй болгох ажлыг зохион байгуулсан байна.<br>0-Үгүй<br>1-Тийм | 0 | 1 | Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулж батлуулах ажлыг зохион байгуулсан. ҮГА-ны даргын 2024 оны 2 дугаар сарын 16-ны А/04 тушаалаар Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталсан болно.<br>Төрийн захиргааны байгууллагын төрийн үйлчилгээний албан хаагчдад мэргэшсэн мэргэшлийн зэргийн болон ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг МУ-ын ЗГ-ын | 70 | 50 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | холбогдох тогтоолд нийцүүлэн зохицуулах ажлын хүрээнд Төрийн үйлчилгээний албан хаагчдад нэмэгдэл олгох 2 төрлийн журмын төслийг шинээр боловсруулж удирдах дээд байгууллагад хүргүүлэв: Үүнд: МУ-ын ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолын дагуу "Геологи уул, уурхайн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох журам", "Геологи, уул уурхай салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдын мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам"-ын төслүүдийг УУХҮЯ-ны тнБД-д 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 1/357 тоот албан бичгээр хүргүүлсэн. | | |
| 67 | 5.3.3. | Геологийн салбарт баримтлах дунд хугацаа /2024-2034/-ны хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулна. | - | Холбогдох бичиг баримт боловсруулагдсан байна.<br>0-Үгүй<br>1-Тийм | 0 | 1 | Тус алба нь 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр 1/41 тоот албан бичгээр "Геологийн салбарт баримтлах дунд хугацаа /2024-2034/-ны хөгжлийн зорилтот хөтөлбөр"-ийг хамтран боловсруулах саналыг Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн.<br>Монгол Улсын Их хурлаас 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл баталж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам болгон өөрчилсөн. Үүнтэй холбогдуулан яамны шинэ бүтэц, зохион байгуулалт, зорилго, зорилтод түвшинтэй уялдуулах зорилгоор яамнаас чиглэл авч ажилласан. | Үнэлэх боломжгүй. | - |
| Зорилт 5.4. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төсвийн гүйцэтгэлд хяналт тавих /Төсөв хуваарилах, зарцуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах эрхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/06 дугаар тушаал/. | | | | | | | | | |
| 68 | 5.4.1 | Байгууллагын санхүүгийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр, санхүүгийн тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, харьяалах дээд байгууллагаар баталгаажуулж, АҮЭБЯ, Үндэсний аудитийн газарт хүргүүлнэ. | - | Хүргүүлсэн тоо | 0 | 2 | Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд 2022 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн А/06 дугаар тушаалаар улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажилд зарцуулах төсвийн эрхийг шилжүүлсэнтэй холбогдуулан Геологийн судалгааны төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн ажлын гүйцэтгэлийг "Улсын төсвийн | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам"-д нийцүүлэн 1-10 сарын буюу гүйцэтгэлийн мэдээг 10 удаа хянаж нэгтгэн, гүйцэтгэлийн мэдээг, УУХҮЯ болон ҮСХороонд хүргүүлж ажиллав.<br>УУХҮ-ийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн А/379 тоот тушаалаар Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд гүйцэтгэх нийт 23 төслийн 40,000.0 сая төгрөг баталсан. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй геологи судалгааны ажлын төсвийг 1-р сард 18 төслийн 452.6 сая төгрөг, 2-р сард 19 төслийн 450.5 сая төгрөг, 3-р сард 22 төслийн 654.6 сая төгрөг, 4-р сард 22 төслийн 646.6 сая төгрөг, 5-р сард 22 төслийн 1.8 тэрбум 6-р сард 19 төслийн 1,2 тэрбум төгрөг, 7-р сард 18 төслийн 1,3 тэрбум төгрөг, 8-р сард 21 төслийн 937,4 сая төгрөг, 9-р сард 21 төслийн 1,0 тэрбум төгрөг, 10-р сард 23 төслийн 8,5 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг хүлээн авсан байна. Үнээс агаарын геофизик-2024 тендер зарлагдаж ажил эхэлсэн. 2024 оны 10 дугаар сарын байдлаар 23 төслийн нийт 23,9 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг хүлээн авч 14.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.<br>Төрийн санд /Геологийн байгууллагын санхүүжилт-100900018019/, /Үндэсний геологийн алба ХОТХяналт-100900018371/, /Үндэсний геологийн алба барьцаа-100900018352/, /10090001853- Үндэсний геологийн алба ТЗ барьцаа/ тоот данснуудаар гүйлгээний эрхийг нээлгэж 23 төслийн гүйцэтгэлийг сар бүр хянаж 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдын "Журам шинэчлэн батлах тухай" А/87 тушаалын дагуу 2024 оны 1,2,3,4,5,6,7,8,9,10 дугаар сарын гүйцэтгэлээр санхүүжилтийн тайланг Сангийн яаманд цаг хугацаанд нь хүргүүлэн ажиллав. | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Тайлант хугацаанд 1-11-р сарын гүйцэтгэлээр 23,4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 23 төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжид олгосон. 2024 оны 12 сард багтаж тайлант хугацааны нийт 1,6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоно. | | |
| 69 | 5.4.2 | 2023 оны ҮГА-ны санхүүгийн тайлан ҮАГ-т хүргүүлж, хянуулна. | - | Хянуулсан тоо | 0 | 12 | ҮГА-ны 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2024 оны 1 дүгээр сарын 25 ны өдрийн 1/74 тоот албан бичгээр хүргүүлж тус газраас хийсэн хяналтын үр дүнд дүгээр “зөрчилгүй” дүгнэлт авсан.<br>Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад заасны дагуу байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийг хөтөлж 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг гаргаж АҮЭБЯ-нд хүргүүлэхэд бэлэн болсон. 2024 оны эхний хагас жилийн тайланд ҮАГ-аас санхүүгийн завсрын аудитын хяналт шалгалт хийгдсэн. | 100 | 100 |
| 70 | 5.4.3 | Батлагдсан санхүүжилтийн хуваарийн дагуу сар бүр улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй геологийн судалгааны ажлын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж, санхүүжүүлж, тайлагнана. | - | Төслийн тоо | 0 | 23 | АҮЭБЯ-ийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн А/379 тоот тушаалаар Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд гүйцэтгэх нийт 23 төслийн 40.0 тэрбум төгрөг баталсан. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй геологи судалгааны ажлын төсвийг 1-р сард 18 төслийн 452.6 сая төгрөг, 2-р сард 19 төслийн 450.5 сая төгрөг, 3-р сард 22 төслийн 654.6 сая төгрөг, 4-р сард 22 төслийн 646.6 сая төгрөг, 5-р сард 22 төслийн 1.8 тэрбум 6-р сард 19 төслийн 1,2 тэрбум төгрөг, 7-р сард 18 төслийн 1,3 тэрбум төгрөг, 8-р сард 21 төслийн 937,4 сая төгрөг, 9 дүгээр сард 21 төслийн 1,0 тэрбум төгрөг, 10 дугаар сард 23 төслийн 8,5 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг хүлээн авсан байна төгрөгийн гүйцэтгэлийг хүлээн авсан байна. Үүнээс агаарын геофизик-2024 тендер зарлаж, ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж 10 сарын байдлаар нийт 15,1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг хүлээн авсан. | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 71 | 5.4.4 | Батлагдсан төлөвлөгөөний дагуу аргачлал хяналтын зардлын төсвийг шинэчлэн батлуулна. | - | Санхүүжүүлсэн төсвийн хэмжээ /сая.төг/ | 0 | - | Үндэсний геологийн албаны даргын 2024 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн А/07 дугаар тушаалаар Геологийн судалгааны ажлын 2024 оны аргачлал хяналтын зардлын төлөвлөгөө, төсвийг баталж, уг батлагдсан төсөвт нийцүүлэн хагас жилийн байдлаар 243.9 сая төгрөгийн худалдан авалтыг зохион байгуулж ажиллав. Худалдан авалтын нийт 7 гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангуулан, гэрээний биелэлтийн актыг гэрээлэгч талтай үйлдэж, хүлээн авч баталгаажуулсан баримтын дагуу АҮЭБЯ-ны Санхүүгийн хэлтсээр хянуулан худалдан авалтыг зохион байгуулж ажилласан. | 100 | 100 |
| 72 | 5.4.5 | Геологийн судалгааны ажлын төсвийн зарцуулалтыг тайлагнана. | - | Тайлагнасан эсэх:<br>0-Үгүй<br>1-Тийм | 0 | 1 | Геологийн судалгааны ажлын ерөнхий төлөвлөгөөг 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/379 дүгээр сайдын тушаалаар баталсан бөгөөд 10 дугаар сарын байдлаар нийт 23 төслийн нийт 23.9 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг хүлээн авч 14.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон. | 100 | 100 |
| 73 | 5.4.6 | Геологийн судалгааны ажлын аргачлал хяналтын зардлыг батлагдсан төсөв, хуульд нийцүүлэн худалдан авах ажлыг зохион байгуулна. | - | Худалдан авалтыг хийсэн эсэх:<br>0-Үгүй<br>1-Тийм | 0 | 1 | Үндэсний геологийн албаны даргын 2024 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн А/07 дугаар тушаалаар Геологийн судалгааны ажлын 2024 оны аргачлал хяналтын зардлын төлөвлөгөө, төсвийг баталж, уг батлагдсан төсөвт нийцүүлэн бүтэн жилийн байдлаар 560.0 сая төгрөгийн худалдан авалтыг зохион байгуулж ажиллав. Худалдан авалтын нийт 14 гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангуулан, гэрээний биелэлтийн актыг гэрээлэгч талтай үйлдэж, хүлээн авч баталгаажуулсан баримтын дагуу УУХҮЯ-ны Санхүүгийн хэлтсээр хянуулан, худалдан авалтыг зохион байгуулсан. | 100 | 100 |
| 74 | 5.4.7 | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн төсвийн хөрөнгөөр | - | Хуулийн хүрээнд зохион байгуулсан эсэх:<br>0 – Үгүй<br>1–Тийм | 0 | 1 | Байгууллагын 2024 оны худалдан авах ерөнхий төлөвлөгөөг 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/344 дүгээр тушаалаар батлуулсан. 2024 онд Харуул хамгаалалтын ажил үйлчилгээ үзүүлэх тухай тендерийг харьцуулалтын аргаар зарлаж “Шүтээн уул” | 70 | 50 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бараа ажил үйлчилгээ худалдан авах, худалдан авалтын төлөвлөгөө батлуулж, зохион байгуулж хэрэгжилтийг тайлагнана. | | | | | ХХК, Мэдээлэл технологийн үйлчилгээ тендерийг харьцуулалтын аргаар зарлаж “Арвис системс ХХК, багаж техник хэрэгсэл тендерийг харьцуулалтын аргаар зарлаж “Ай Ти Зон” ХХК шалгарсан. Бичиг хэргийн материал худалдан авах тендер амжилтгүй болж цуцлагдсан бөгөөд шууд худалдан авалт хийж байна..<br>Мөн 2024 онд гүйцэтгэхээр төсөвт тусгагдсан ҮГА-ны байрны дээврийн засвар, ариун цэврийн өрөөнүүдийн засвар, барилгын дотоод засварын ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааг зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Эдгээр ажлуудыг ажлын даалгаврыг боловсруулахдаа тухайн хийж гүйцэтгэх ажлын зураг, төсвийг эхлэн боловсруулж, холбогдох эрх бүхий *төсөвчинтэй гэрээ байгуулж,* ажил үйлчилгээний *төсөв* болон түүнтэй холбогдох бусад тооцоо судалгааг гаргаж багц хэд хэдэн удаа зарлаж амжилтгүй болж дахин тендер зарлаад байна. | | |
| 5.5 Төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлэх | | | | | | | | | |
| 75 | 5.5.1 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, орлого, зарлагын гүйлгээний мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлнэ. | - | Мэдээлэл байршуулсан тоо /сар бүр/ | 0 | 12 | Үндэсний геологийн албаны 2024 оны хагас жилийн эцсийн байдлаарх санхүүгийн мэдээллийг шилэн дансанд хуулийн хугацаанд байршуулан ажилласан. Үүнд: Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Геологи судалгааны ажлын санхүүжилт, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын гүйлгээ, тайлан, аудитлагдсан тайлан, аудитын гэрчилгээ, акт, албан шаардлага, бусад мэдээлэл багтаж байна.<br>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг дараах байдлаар тайлагнаж байна. Үүнд:<br>-Төсөв, санхүүтэй холбогдолтой төлөвлөгөө, тайлан,<br>-5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын гүйлгээний мэдээллийг цаг хугацаанд нь олон нийтэд нээлттэй мэдээлсэн. | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | -Байгууллагын бүтэц, орон тооны мэдээллийг шилэн дансанд 2024 оны 1 дүгээр сараас сар бүр шинэчлэн оруулж ажиллав.<br>-Байгууллагын цахим хуудсанд хагас жилийн байдлаар салбарын үйл ажиллагаатай холбоотой 14 мэдээ, мэдээллийг байршуулсан.<br>Шилэн дансны 2024 оны 1, 2 дугаар улирлын тайланг гаргаж, хуулийн хугацаанд АҮЭБЯ-ны Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газарт хүргүүлсэн.<br>Байгууллагын мэдээлэл, лавлагааны 70181208 дугаарын утсанд ирж буй дуудлагад тогтмол хариу мэдээлэл, лавлагаа өгч, холбогдох ажилтнуудад дуудлагыг шилжүүлэн, хяналт тавьсан. | | |
| 76 | 5.5.2 | Төсвийн орлого болон зарлагын хэмжээ, хөрөнгө оруулалтыг тооцон, 2024 оны төсвийн тодотгол, 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийг боловсруулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ. | - | Төсвийн төсөөлөл хүргүүлсэн байна.<br>0-Үгүй;<br>1-Тийм | 0 | 1 | -Үндэсний геологийн албаны 2025 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал, 2025-2026 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөөллийг боловсруулан, 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 1/312 дугаар албан бичгээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлсэн.<br>-Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг Сангийн яамны хөрөнгө оруулалтын программ http://pimis.e-nation.mn/-д оруулсан.<br>Улсын төсөвт 2024 оны 11 дүгээр сарын байдлаар 279,2 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 2024 онд төвлөрүүлэх орлогоо давуулан биелүүлсэн. | 100 | 100 |
| 77 | 5.5.3 | Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй нийт геологийн судалгааны ажлын сар бүрийн төсвийн гүйцэтгэл, зарцуулалтын мэдээ болон улирал бүрийн тайланг бэлтгэн, Үндэсний статистикийн хороо, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд тогтоосон хугацаанд хүргүүлнэ | | Хүргүүлсэн мэдээ, тайлан тоо | 0 | 16 | Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй нийт геологийн судалгааны ажлын тайланг тогтоосон хугацаанд хүргүүлсэн. Үүнд:<br>Үндэсний статистикийн хороонд: 2024/01/05 №2/20, 2024/02/02 №2/93, 2024/03/05 №1/156, 2024/04/05 №4/223, 2024/05/07 №4/290, 2024/06/06 №4/358, 2024/06/27 №4/408, 2024/07/05 №3/483, 2024/08/05 №3/483, 2024/09/02 №4/536, 2024/10/01 №1/594, 2024/11/01 №4/653, | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд: 2024/02/02 №1/91, 2024/03/05 №1/155, 2024/04/05 №1/219, 2024/05/07 №1/288, 2024/06/06 №1/361, 2024/06/27 №1/418, 2024/08/01 №1/479, Аж үйлдвэр эрдэс баялгийн яаманд: 2024/09/02 №1/535, 2024/10/01 №1/593, 2024/11/01 №1/650 Сангийн яаманд: 2024/02/02 №1/92, 2024/03/05 №1/154, 2024/04/05 №1/218, 2024/05/07 №1/287, 2024/06/06 №1/360, 2024/6/27 №1/417, 2024/08/01 №1/480, 2024/09/02 №1/534, 2024/10/01 №1/592, 2024/11/01 №1/651 дугаар албан бичгүүдээр геологийн судалгааны ажлын сар бүрийн төсвийн гүйцэтгэл, зарцуулалтын мэдээ болон улирал бүрийн тайланг хүргүүлсэн. | | |
| 78 | 5.5.4 | Байгууллагын архив байгуулах тоног төхөөрөмжийн судалгаа гаргах, архивын баримтыг стандартын дагуу хадгалах нөхцөлийг бүрдүүлэх, төсөв хөрөнгө шийдүүлэх санал боловсруулж, УУХҮЯ-нд танилцуулна. | - | Танилцуулсан эсэх<br>0-Үгүй;<br>1-Тийм | 0 | 1 | Архивын баримтын хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, архивын баримтыг зориулалтын байранд стандартын дагуу хадгалах нөхцөл бүрдүүлэх зорилгоор байгуулагдсан ажлын хэсгийн ажлууд хийгдэж, Лүндээ очир ХХК-тай гэрээ хийж 8 ш нягтруулсан шүүгээ суурилуулан, ХН-ийг хүлээн авахад бэлэн болсон.<br>Архивын баримтын хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, архивын баримтыг зориулалтын байранд стандартын дагуу хадгалах нөхцөл бүрдүүлж байгаа бөгөөд 2020-2023 оны архивын хавтаст баримтыг тавиур шүүгээнд байрлуулж, шүүгээний заагуур болон данс бүртгэлийг хийж байна. | 70 | 70 |
| Зорилт 5.6. Байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх санал боловсруулах, тайлагнах, хариуцлага тооцох, урамшуулах, дотоодын хяналтын тогтолцоог сайжруулах, 2023 оны зорилтот түвшин, хүрсэн түвшний зөрүүг бууруулах. | | | | | | | | | |
| 79 | 5.6.1 | Байгууллагын 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг тогтоосон хугацаанд тайлагнана. | - | Төлөвлөгөө, тайлангийн тоо | 0 | 3 | -Төсвийн шууд захирагчийн 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөө Төсвийн ерөнхийлөн захирагчаар батлагдаж, 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 1/232 дугаар албан бичгээр ҮГА-нд ирсэн.<br>-Засгийн газрын тогтоолоор батлагдсан Хяналт шинжилгээ, үнэлгээний журмын хүрээнд Үндэсний геологийн албаны 2024 | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | оны гүйцэтгэлийн тайланг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад 2024 оны 06 дугаар сар, 12 дугаар сард Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдад хүргүүлсэн.<br>-Нийт 83 ажил арга хэмжээ төлөвлөсөн ба, эхний хагас жилд 70 арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн тайлагнасан. 13 арга хэмжээний хэрэгжилтийг III-IV дүгээр улиралд төлөвлөсний дагуу хэрэгжилтийг хангаж тайлагнав.<br>Хүрсэн түвшин: Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдад хугацаанд нь тайлагнасан ба Албаны үнэлгээг 96,67%-тай үнэлж, Сайдад хүргүүлсэн. | | |
| 80 | 5.6.2 | Байгууллагын салбарын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг байгууллагын удирдлагад танилцуулах, хяналтад авах, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд тайлагнана. | - | Засгийн газрын тогтоолоор батлагдсан журмаар, хүргүүлсэн тайлангийн тоо | 0 | 2 | -УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдаанаар “журам маягт шинэчлэн батлах тухай” 5 дугаар тогтоол батлагдаж, Төрийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг бүрдүүлэхтэй холбоотой журам, маягт, жагсаалт батлагдсан. Үүнтэй холбогдуулан АТГ-аас зарласан сургалтад холбогдох ажилтныг хамруулж, мэдээллийг албаны олон нийт хэсэгт мэдээлж ажиллав.<br>-УИХ-ын 2007 оны 27 дугаар тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэгт ҮГА-наас ЭБТЭЗХ-ийн дарга Н.Мөнхбилэг ажиллаж байна.<br>-МУ-ын ЗГ-ын Төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай тогтоолын дагуу цалингийн мэдээллийг мэдээллийг шинэчилсэн.<br>-МУ-ын ЗГ-ын 2024 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн 198 дугаар тогтоолын дагуу Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем-ийг хэрэглээнд нэвтрүүлэх шийдвэр гарсны дагуу ҮГА-ны төрийн албан хаагчдын мэдээллийг уг системд үнэн зөв, бүрэн гүйцэт оруулсан.<br>-МУ-ын ЗГ-ын 2024 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор Мал аж ахуйн салбарт үүсээд буй нөхцөл байдал, | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хаваржилтын хүндрэлийг хохирол багатай даван туулах зорилгоор "Малчдадаа тусалъя аян"-ыг үндэсний хэмжээнд зохион байгуулах ажлын хүрээнд УУХҮЯ, Улаан загалмайн нийгэмлэг хамтран санаачилсан /Байгалийн гамшгийн эсрэг баялаг бүтээгчид хамтдаа" аянд УТХ-өөр геологийн судалгааны ажил гүйцэтгэгч ААН-үүдийг уриалсан. ҮГА-ны албан хаагчид улаан загалмайн нийгэмлэгийн дансанд 1 албан хаагчийн 1 өдрийн цалинг хандивлаж, албаны даргын тушаалаар баталгаажуулсан. | | |
| 81 | 5.6.3 | Алсын хараа-2050, Шинэ сэргээлтийн бодлого 2022-2025, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөр төслүүдийг тайлагнах, тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлнэ. | - | Засгийн газрын тогтоолоор батлагдсан журмаар, хүргүүлсэн тайлангийн тоо | 0 | 1 | Үндэсний геологийн албаны хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан дараах бодлогын баримт бичгүүдийн арга хэмжээний 2024 оны хэрэгжилтийн явцыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны холбогдох албан хаагчид, Геологийн бодлогын газарт тогтмол цахим хэлбэрээр хүргүүлсэн. Үүнд:<br>-Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт,<br>-Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт<br>-"Тэрбум мод Үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд Налайх дүүргийн цэцэрлэгт хүрээлэнд албан байгууллагаараа Мод тарих аянд нэгдэн ажиллав. | 100 | 100 |
| 82 | 5.6.4 | УИХ, ЗГ-ын тогтоол, шийдвэр, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын биелэлтүүдэд хяналт шинжилгээ үнэлгээ хийх, хүргүүлнэ. | - | Дээд газраас ирүүлсэн чиглэлийн дагуу хүргүүлсэн тайлангийн тоо | 0 | 1 | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын биелэлтүүдэд хяналт хийгдсэн. Холбогдох мэдээллийг тухай бүр хүргүүлсэн. | 100 | 100 |
| 83 | 5.6.5 | "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх журам"-ын дагуу албан хаагчийн гүйцэтгэлийн тайланд үнэлгээ | - | ЗГ-ын тогтоол, ЗГХЭГ-ын даргын тушаалын дагуу хэрэгжүүлсэн ажлын тоо | 0 | 1 | ЗГХЭГ-ын даргын 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 98 дугаар тушаалаар батлагдсан Аргачлал батлах тухай журмын дагуу төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө 1-р улиралд зохион байгуулж боловсруулж, батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх ажлыг зохион байгуулав. | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хийж, нэгтгэх, үнэлгээний багаар хянан, баталгаажуулна. | | | | ҮГА-ны ТЗ-ны албан хаагчдын зэрэг дэв нэмэгдүүлэх хүсэлтийг боловсруулж Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны дэргэд Төрийн албаны салбар зөвлөлд 2 удаа хүргүүлэв. | | |
| **Дундаж** | | | | | | | **96.67** | **90.36** |

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР